# Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт

**Зам, тээврийн яам**

**2025 оны IV улирал**

| Шийдвэрийн д/д | Заалтын д/д | Шийдвэрийн нэр, огноо, дугаар | Холбогдох заалтын агуулга | Хэрэгжүүлэх нэгж | Хэрэгжилтын явц | Өөрийн үнэлгээ | Дээд шатны байгууллага | Үнэлгээний тайлбар | Хяналтаас хасах | Хяналтаас хасах |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| **ЗГ-ын тогтоол** | | | | | | | | | | |
| 1 | 1 | Нийслэл Улаанбаатар хотын талаар авах зарим арга хэмжээний тухай 2021-05-19 Дугаар 2021_146 | 6. Нийслэл Улаанбаатар хотын төвлөрлийг сааруулах, дагуул хот, суурьшлын бүсийг үе шаттайгаар байгуулах зорилгоор Богдхан төмөр замыг барьж ашиглалтад оруулах ажлыг эрчимжүүлэхийг Зам, тээврийн хөгжлийн сайд Л.Халтарт, шаардагдах санхүүжилтийн эх үүсвэрийг шийдвэрлэхийг Сангийн сайд Б.Жавхланд, Богдхан уулын дархан цаазат газрын хилийн заагт өөрчлөлт оруулах асуудлыг судалж, хууль тогтоомжийн хүрээнд шийдвэрлүүлэхийг Байгаль орчин, аялал жуулчлалын сайд Н.Уртнасанд, Нийслэл Улаанбаатар хот, Төв аймаг хооронд үүссэн хилийн цэсийн маргааныг судалж, хууль тогтоомжид нийцүүлэн шийдвэрлүүлэх арга хэмжээ авахыг Барилга, хот байгуулалтын сайд Б.Мөнхбаатар, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагч Д.Сумъяабазар, Төв аймгийн Засаг дарга Д.Мөнхбаатар нарт тус тус даалгасугай. | тзг | Богдхан төмөр зам төсөл нь хөрөнгө оруулалт, зам салаалах цэгийн асуудлаар ОХУ-ын талтай тохиролцож чадаагүй зэрэг шалтгаануудын улмаас түр зогсоод байна. | | | | Үгүй | |
| 2 | 2 | Монгол хэлний тухай хуулийг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай 2022-01-05 Дугаар 2022_7 | 5. Монгол хэлний тухай хуулийн хэрэгжилтийг хангах дараахь арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг төсвийн ерөнхийлөн болон шууд захирагч нарт тус тус даалгасугай:<br><br>5.1. эрх бүхий судалгааны байгууллагатай хамтран салбарын мэргэжлийн нэр томьёог оруулах, шинээр үүсгэх, жигдлэх, толилох ажлыг зохион байгуулах, нийтийн хэрэглээнд нэвтрүүлэх;<br><br>5.2. төрийн байгууллагын цахим хуудас, сонин хэвлэлд нийтэлж байгаа мэдээ, мэдээллийг 2022 оноос эхлэн кирилл, монгол бичгээр зэрэгцүүлэн нийтэлж хэвшүүлэх;<br><br>5.3. төрийн байгууллагын шийдвэр, албан бичгийг энэ тогтоолын 4-т заасан дүрэм, журам, заавар, стандартын дагуу хос бичгээр хөтлөх ажлыг турших;<br><br>5.4. төрийн албан хаагчдын монгол хэл, үндэсний бичгийн мэдлэг чадварыг дээшлүүлэх арга хэмжээ авах, сургалтын хөтөлбөр, төлөвлөгөө жил бүр баталж мөрдүүлэх;<br><br>5.5. төрийн байгууллагын гадна болон өрөө тасалгааны хаяг, албан хаагчдын нэрийн хуудсыг монгол бичгээр үйлдэж, хэвшүүлэх. | тзуг | 5.1.Салбарын мэргэжлийн нэр томьёоны товхимолыг хэвлүүлж,2022 онд олон нийтэд хүртээл болгосон. 5.2.Байгууллагаараа "Хүмүүн бичиг" сонины байнгын хэрэглэгч болж, яамны цахим хуудсанд Монгол бичгийн мэдээний цонх нээж 4 удаагийн мэдээллийг кирилл, монгол бичгээр зэрэгцүүлэн нийтэлсэн.<br>5.3.Монгол бичгээр үйлдэх баримт бичгийн хэвлэмэл хуудас, түүний бүрдэлд тавих стандарт/MNS6395:2022/-ын дагуу тус яаманд ашиглагдаж байгаа бүх хэвлэмэл хуудсыг хэвлүүлсэн. Мөн Төрийн нарийн бичгийн даргаас гарч байгаа байнга хадгалах баримт бичиг болох ажилд томлох, шилжүүлэн томлох тушаалыг хос бичгээр хөтөлж байна.-салбарын ажилтан, албан хаагчдад олгогдож байгаа яамны "Жуух бичиг"-ийг хос бичгээр батлан хэрэглэж байна. Төрийн нарийн бичгийн даргын "Яамны албан хэргийг хос бичгээр хөтлөн явуулах тухай" 2025 оны А/07 дугаар тушаалыг батлуулан хэрэгжүүлж байна.<br>5.4.Зам, тээврийн хөгжлийн сайдын 2022 оны А/07 дугаар тушаалаар МУ-ын Ерөнхийлөгчийн дэргэдэх Хэлний бодлогын үндэсний зөвлөлийн Зам, тээврийн хөгжлийн яамны салбар зөвлөлийн бүрэлдэхүүнийг шинэчлэн батлуулж, хэрэгжилтийг ханган дараах ажлыг хийв:-Нийт албан хаагчдын дунд Монгол бичгээр унших, бичих мэдлэгийн түвшинг тогтоох сорилын арга хэмжээг зохион байгуулсны үндсэн дээр монгол бичгийн 27 удаагийн сургалтаар суурьгүй анхан шатны 58, суурьтай анхан шатны сургалтад 93 албан хаагч, гүнзгий шатны 15 удаагийн сургалтад 33 албан хаагчийг хамруулж гэрчилгээ олгосон. -"Кирилл бичгийн зөв бичих зүй, найруулга зүйн" 3 удаагийн сургалтаар 74, Баримт бичиг боловсруулахад анхаарах асуудал" сэдэвт 6 удаагийн | | | | Үгүй | |
| 3 | 3 | Арцсуурь-Нарийнсухайт-Шивээхүрэн, Хөөт-Чойбалсан, Хөөт-Бичигт чиглэлийн төмөр замын төслийн талаар авах зарим арга хэмжээний тухай 2022-03-16 Дугаар 2022_116 | 6. "Монгол-Оросын хилийн төмөр замын харилцааны тухай хэлэлцээр"-т холбогдох өөрчлөлт оруулахыг Зам, тээврийн хөгжлийн сайд Л.Халтарт даалгасугай. | тзг | Баруун босоо: "Монголын төмөр зам" ТӨХК болон "Эссенз саплайз" ХХК нар "Арцсуурь-Нарийнсухайт-Шивээхүрэн төмөр зам" ХХК-ийн хувьцаа эзэмшигчдийн гэрээ"-г 2023.06.09-ний өдөр гарын үсэг зурж баталгаажуулсан. Монгол Улсын Засгийн газрын 2023.08.30-ны 35 дугаар тэмдэглэлээр тус чиглэлийн төмөр замын төслийг хэрэгжүүлэх тусгай зориулалтын компанитай концессын шууд гэрээ байгуулах талаар дүгнэлт гаргахыг ТХААГ-т, дүгнэлтийг үндэслэн хэлэлцээ хийж, зохих журмын дагуу гэрээ байгуулахыг ЗТХСайдад даалгасан. ЗТХСайдын тушаалаар концессын хэлэлцээ хийх Ажлын хэсгийг байгуулан хэлэлцээр амжилттай хийгдэж гэрээний төслийг | | | | Үгүй | |
| 4 | 4 | Хууль хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай 2022-05-25 Дугаар 2022_204 | 6. Төрийн болон орон нутгийн өмчид бүртгэлтэй бүх төрлийн автомашинд тод дэвсгэр өнгө бүхий улсын дугаар олгох арга хэмжээг 2022 онд багтаан зохион байгуулахыг Зам, тээврийн хөгжлийн сайд Л.Халтар, Сангийн сайд Б.Жавхлан, Хууль зүй, дотоод хэргийн сайд Х.Нямбаатар нарт даалгасугай. | атбзг | Төрийн болон орон нутгийн өмчид бүртгэлтэй нийт 18,761 тээврийн хэрэгслээс 2025 оны 05 дугаар сарын 31-ны өдрийн байдлаар 12,935 тээврийн хэрэгслийн улсын бүртгэлийн дугаарыг өөрчлөөд байна. | | | | Үгүй | |

| | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 5 | 5 | Хувийн хэвшил, төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлэх ажил үйлчилгээний талаар авах зарим арга хэмжээний тухай 2022-09-14 Дугаар 2022_340 | 1. Төрийн үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах, төр-хувийн хэвшлийн түншлэлийг өргөжүүлэх, бизнесийн үйл ажиллагаанд төрийн оролцоог багасгах зорилгоор төрийн зарим чиг үүрэг, ажил үйлчилгээг сонгон шалгаруулалтын үндсэн дээр зохих хууль журмын дагуу хувийн хэвшил, төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлэх арга хэмжээ авч ажиллахыг төсвийн ерөнхийлөн захирагч болон аймаг, нийслэлийн Засаг дарга нар, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар (Б.Цэнгэл)-т тус тус үүрэг болгосугай. | мтх | | | | | | |
| | | | | тзуг | Байруудын нийтлэг үйлчилгээ, сургалтууд, салбарын мэргэшлийн зэрэг олгох үйл ажиллагаа, мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх болон бусад тусгай зөвшөөрөл олгох ажлыг зохион байгуулах чиг үүрэг (аж ахуйн үйл ажиллагаатай холбоотой), харьяа амралт, сувилал, сургалтын төвийн үйл ажиллагааг тооцоо, судалгаа хийсний үндсэн дээр хууль тогтоомжийн хүрээнд дээрх бүх ажил үйлчилгээг гэрээний үндсэн дээр хийж гүйцэтгэж байна. Мөн “Хувийн хэвшил, төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлэх ажил үйлчилгээний талаар авах арга хэмжээний тухай” Засгийн газрын 2022 оны 340 дүгээр тогтоолын хэрэгжилтийг хангах ажлын 2023 оны төлөвлөгөөг боловсруулан 2022.09.26-ны өдөр ЗГХЭГ-ын референт Сарангэрэлд, 2023.04.14-ны өдөр ЗГХЭГ-ын референт | | | | Үгүй | |
| | 6 | | 3. Эрхлэх асуудлын хүрээнд хамаарах зарим чиг үүрэг, ажил үйлчилгээг хувийн хэвшил, төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлэх чиглэлээр шаардлагатай бол холбогдох хууль тогтоомжид өөрчлөлт оруулах санал боловсруулж, хэлэлцүүлэхийг Засгийн газрын гишүүдэд даалгасугай. | тзуг | ЗГХЭГ-аас ТББ болон хувийн хэвшлээр гүйцэтгүүлэх боломжтой ажлын талаарх судалгааг нэгтгэн танилцуулсан ба дараагийн шатны даалгавар гарсан байна. Ерөнхий сайдын 2022 оны 11 сарын 17 өдрийн 11 дугаар "Төр, хувийн хэвшлийн хамтын ажиллагааг өргөжүүлэх талаар авах зарим арга хэмжээний тухай" албан даалгавраар холбогдох үүрэг чиглэлийг Засгийн газрын гишүүдэд | | | | Үгүй | |
| 6 | 7 | “Зүүнбаян төмөр зам” ХХК-ийн талаар авах арга хэмжээний тухай 2022-11-30 Дугаар 2022_434 | 2. Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн төмөр замын төслийн хэрэгжилт, “Зүүнбаян төмөр зам” ХХК-ийн үндсэн болон санхүүгийн үйл ажиллагаанд хяналт шалгалт хийж, зохих дүгнэлт гаргуулах арга хэмжээ авахыг Зам, тээврийн хөгжлийн сайд С.Бямбацогт, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар (Б.Цэнгэл), “Эрдэнэс Монгол” ХХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөл (Ш.Мөнхцэрэн)-д даалгасугай. | тзг | Тавантолгой зүүнбаян чиглэлийн төмөр зам нь 2023.06.20-ны өдрийн 2023/006 дугаар УК-ын актаар байнгын ашиглалтад орсон.Зүүнбаян төмөр зам ХХК нь Засгийн газрын хуралдаанаас гаргасан шийдвэрийн дагуу татан буугдсан. | | | | Үгүй | |
| | 8 | | 4. Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн төмөр замын төсөлд “Эрдэнэс Тавантолгой” ХК-аас оруулсан хөрөнгө, санхүүжилтийг “Монголын төмөр зам” ТӨХК-ийн тээвэрлэлтийн үйл ажиллагааны орлого, холбогдох бусад эх үүсвэрээс барагдуулах арга хэмжээ авахыг Зам, тээврийн хөгжлийн сайд С.Бямбацогт, Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Ж.Ганбаатар, “Монголын төмөр зам” ТӨХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөл (Ц.Одхүү)-д тус тус даалгасугай. | мтз | “Монголын төмөр зам” ТӨХК нь орлогын эх үүсвэр нь ачаа тээвэрлэлт, төрийн өмчийн түрээсээр олдог. 2025 оны 02 дугаар сарын байдлаар 3,007.4 мянган тн. ачаа тээвэр хийж 106.2 тэрбум төгрөгийн борлуулалт хийсэн 2025 онд 4,247.0 мянган тн. ачаа тээвэр хийж 183.3 тэрбум төгрөгийн борлуулалт хийхээр төлөвлөсөн. Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн төмөр замын төслийн | | | | | |
| | | | | тзг | Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн төмөр замын төсөлд “Эрдэнэс Тавантолгой” ХК-аас Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн төмөр замын төслийн санхүүжилт “Эрдэнэс Тавантолгой” ХК-аас оруулсан бөгөөд хөрөнгө, санхүүжилтийг “Монголын төмөр зам” ТӨХК-ийн тээвэрлэлтийн үйл ажиллагааны орлого, холбогдох бусад эх үүсвэрээс барагдуулахаар "Санхүүжилтийн гэрээ"-г 2024 оны 01 дүгээр сард байгуулан ажиллаж байна.<br>“Монголын төмөр зам” ТӨХК нь орлогын эх үүсвэр нь ачаа тээвэрлэлт, төрийн өмчийн түрээсээр олдог. 2024 оны 5 дугаар сарын 20-ны байдлаар 32,9 тэрбум төгрөгийн борлуулалтаар 896 мянган тн. ачаа тээвэр хийгээд байна. Тавантолгой-Зүүнбаян | | | | Үгүй | |
| 7 | 9 | “Тавантолгой төмөр зам” ХХК-ийн талаар авах зарим арга хэмжээний тухай 2022-11-30 Дугаар 2022_435 | 2. “Тавантолгой төмөр зам” ХХК-ийн хувьцаа эзэмшигчийн эрхийг “Монголын төмөр зам” ТӨХК хэрэгжүүлэхээр тогтоосугай.<br><br>2. Тавантолгой-Зүүнбаян, Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн төмөр замын тээвэрлэлтийн үйл ажиллагаа, хөдөлгөөний аюулгүй байдлыг хангуулах асуудлыг нэгдсэн удирдлага, зохион байгуулалтаар хангаж ажиллахыг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар (Б.Цэнгэл), “Монголын төмөр зам” ТӨХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөл (Ц.Одхүү)-д, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Зам, тээврийн хөгжлийн сайд С.Бямбацогтод тус тус даалгасугай. | тзг | Тавантолгой-Гашуунсухайт чиглэлд 2024 оны 11 дүгээр сарын 17-ны өдрийн байдлаар 1.55 сая.тн, Тавантолгой-Цогтцэций чиглэлд 2.15 сая.тонн, нийт 3.7 сая.тонн ачааг тээвэрлэж, ачаа тээвэрлэлтийг галт тэрэгний болон хөдөлмөрийн аюулгүй байдлыг бүрэн хангаж ажилласан.Тээвэрлэлтийн үйл ажиллагаанд доголдол үүсэх, хэвийн үйл ажиллагааг тасалдуулахгүй байх, хөдөлгөөнтэй холбоотой ажлын байрыг нэмэгдүүлэх зорилгоор 2024 оны 05 дугаар сарын 20-ны өдрийн Гүйцэтгэх захирлын Б/269 тоот тушаалаар газар, нэгжүүдээс нийт 12 орон тоог Тээврийн удирдлагын газарт шилжүүлэн, хүний нөөцийн бүрдүүлэлтийг шуурхай хангаж, 2024 оны 07 дугаар сарын 19-ний өдрийн А/106 дугаар тушаалаар Вагоны аж ахуйн 4 орон тоог Зүтгүүрийн аж ахуйн хэлтэст шилжүүлж, Вагоны аж ахуйн 4 албан тушаалын нэршлийг өөрчилж хүний нөөцийн бүрдүүлэлтийг шуурхай хангаж ажиллаж байна. Төмөр замын тээвэрлэлт нь байгаль орчинд ээлтэй тээврийн төрөл бөгөөд тээвэрлэлтийн үйл ажиллагааг задгайгаар бус чингэлгээр тээвэрлэлт зохион байгуулж байгаа нь ачиж, буулгахад нүүрс хийсэх, байгаль орчинд бохирдол үүсгэхгүйгээр шийдэж байна.Тавантолгой-Зүүнбаян чиглэлд 2.5 сая.тн ачаа тээвэрлээд байна. Үүнээс Зүүнбаян-Цогтцэций чиглэлийн төмөр замын | | | | Үгүй | |

| | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | 10 | | 4. Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн төмөр замын бүтээн байгуулалтын ажлыг бүрэн дуусгахад шаардагдах эх үүсвэрийг тооцож саналаа танилцуулахыг Зам, тээврийн хөгжлийн сайд С.Бямбацогт, Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Ж.Ганбаатар, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар (Б.Цэнгэл), “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн гүйцэтгэх удирдлага (Ж.Ганбат)-д тус тус даалгасугай. | тзг | Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн төмөр замын бүтээн байгуулалтын ажлыг бүрэн дуусгахад шаардагдах эх үүсвэрийг тооцож танилцуулсаны дагуу УИХ-ын 2023 оны 38 дугаар тогтоол гарсан. Уг тогтоолын дагуу тус хил дамнасан төмөр замын зураг төслийг гүйцэтгэж, магадлагдсан төсвийн дагуу гүйцэтгэх, санхүүжүүлэх асуудлыг бүрэн шийдвэрлэсэн. | | | | Үгүй | |
| 8 | 11 | “Тавантолгой төмөр зам” ХХК-ийн талаар авах зарим арга хэмжээний тухай 2022-12-12 Дугаар 2022_459 | 3.3. . Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн төмөр замын бүтээн байгуулалтын төсөлд зарцуулсан хөрөнгөд хөндлөнгийн аудит хийлгэж, дүгнэлт гаргуулах, хууль зөрчсөн, ашиг сонирхлын зөрчилтэй, компанийн эрх ашигт нийцээгүй гэрээ хэлцэл, үйл ажиллагааг хуулийн байгууллагад шилжүүлэн шалгуулах арга хэмжээ авахыг Засгийн газрын онцгой бүрэн эрхт төлөөлөгч Н.Мягмар, Хууль зүй, дотоод хэргийн сайд Х.Нямбаатар, Зам, тээврийн хөгжлийн сайд С.Бямбацогт нарт; | тзг | Үндэсний Аудитын газраас хийсэн “Тавантолгой-Гашуунсухайт, Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн төмөр замын бүтээн байгуулалтад зарцуулсан хөрөнгө, үр дүн” сэдэвт гүйцэтгэлийн Аудитын талбарын ажил дуусч, “Төрийн аудитын тухай хууль”-ийн 18 дугаар зүйлийн 18-ын 1 дэх хэсэгт заасан дагуу тайлангийн төсөлд санал авахаар 2023 оны 07 дугаар сарын 31-ний өдрийн 01/1421 тоот албан бичиг ирүүлсэн. Энэ дагуу дотооддоо зохион байгуулалтын арга хэмжээ авч тайлан, түүний дүгнэлт хэсгүүдтэй газар, хэлтсийн дарга, инженерүүдийг нэг бүрчлэн танилцуулж зарим дүгнэлтэд хариу санал, тайлбаруудыг бэлтгүүлж, 2023 оны 08 дугаар сарын 18-ны | | | | Үгүй | |
| 9 | 12 | Улаанбаатар хотын “Шинэ тойрог зам”-ыг барьж байгуулах тухай 2022-12-21 Дугаар 2022_476 | 2. “Шинэ тойрог зам” төслийн бүрэлдэхүүн хэсэг болох Туулын авто зам, гүүрэн байгууламж болон Нисэхийн хурдны замыг Туулын авто замтай холбох авто замыг барьж байгуулах ажлыг хариуцан хэрэгжүүлэхийг Зам, тээврийн хөгжлийн сайд С.Бямбацогтод, Улаанбаатар-Дархан чиглэлийн замаас Баянзүрхийн гүүр хүртэлх авто замыг барьж байгуулах ажлыг хариуцан хэрэгжүүлэхийг Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагч Д.Сумъяабазарт тус тус даалгасугай. | азбзг | Концессын тухай хууль 2023.12.31-ний өдрөөс хүчингүй болж, Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хууль 2024.01.01-ний өдрөөс хүчин төгөлдөр мөрдөгдөж эхэлсэн. Мөн Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн дагуу концессын гэрээ байгуулагдаагүй, гарын үсэг зурагдаагүй төслүүдийг Концессын хуулийн хүрээнд цааш үргэлжлүүлэх боломжгүй нөхцөл байдал үүссэн. Туулын авто замыг Нисэхийн хурдны авто замтай холбох Наадамчдын гудамжны авто зам дээгүүр тавих 800 у/м гүүрийн зураг төслийг 2024.06.30-нд боловсруулж бүрэн дуусгаж, | | | | Үгүй | |
| | 13 | | 3. Туулын авто зам, гүүрэн байгууламж, Улаанбаатар-Дархан чиглэлийн замаас Баянзүрхийн гүүр хүртэлх авто зам, Туулын авто замаас Нүхтийн авто зам хүртэлх авто замыг тус тус “Төрийн өмчийн концессын зүйлийн жагсаалт”-д концессын боломжит төрлийг сонгон тусгуулж, ажлын тоо хэмжээ, цар хүрээгээр багцлан зөвлөх болон гүйцэтгэгчийг холбогдох хууль, журмын дагуу сонгон шалгаруулах ажлыг богино хугацаанд үр дүнтэй зохион байгуулж ажиллахыг Эдийн засаг, хөгжлийн сайд Ч.Хүрэлбаатар, Зам, тээврийн хөгжлийн сайд С.Бямбацогт, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагч Д.Сумъяабазар нарт, шаардлагатай дэмжлэгийг үзүүлж ажиллахыг Сангийн сайд Б.Жавхланд тус тус даалгасугай. | азбзг | Засгийн газрын 2023 оны 253, 355 дугаар тогтоолоор “Шинэ тойрог зам” төслийн урд хэсэг, Туулын авто замыг, мөн "Туулын замыг Нисэхийн хурдны авто замтай холбох Наадамчдын авто зам дээгүүр барих 800у/м гүүрэн байгууламжийн төслийг Төрийн өмчийн концессын зүйлийн жагсаалтад тусган, концесс олгох уралдаант шалгаруулалтыг зарласан боловч Концессын тухай хууль 2023.12.31-ний өдрөөс хүчингүй болж, Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хууль 2024.01.01-ний өдрөөс хүчин төгөлдөр мөрдөгдөж эхэлсэн. Мөн Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн дагуу концессын гэрээ байгуулагдаагүй, гарын үсэг зурагдаагүй төслүүдийг концессын тухай хуулийн хүрээнд цааш үргэлжлүүлэх боломжгүй нөхцөл байдал үүссэн. Иймд 2024.02.13-ний өдрийн 1/623 дугаартай Сайдын албан бичгээр Нийслэлийн засаг даргын тамгын газарт “Шинэ тойрог зам” төслийн урд хэсэг, Туулын авто авто зам болон Наадамчдын гүүрийн зураг | | | | Үгүй | |
| | 14 | | 7. “Шинэ тойрог зам” төслийн техник, эдийн засгийн үндэслэл, барилгын ажлын нарийвчилсан зураг төслийг баталгаажуулахад шаардлагатай техникийн нөхцөлийг шуурхай олгож ажиллахыг Эрчим хүчний сайд Б.Чойжилсүрэн, Зам, тээврийн хөгжлийн сайд С.Бямбацогт, Барилга, хот байгуулалтын сайд Б.Мөнхбаатар, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагч Д.Сумъяабазар, холбогдох байгууллагын удирдлагад үүрэг болгосугай. | азбзг | Нийслэлд шилжүүлсэн бөгөөд Зам, тээврийн яамны зүгээс ТЭЗҮ, зураг төслийг баталгаажуулах, техникийн нөхцөлийг олгоход дэмжлэг үзүүлэн хамтран ажиллаж байна. | | | | Үгүй | |
| 10 | 15 | “Шинэ Хархорум” хотын бүтээн байгуулалтын асуудал хариуцсан захиргаа байгуулах тухай 2023-02-01 | 4. “Шинэ Хархорум” хотын бүтээн байгуулалтын асуудал хариуцсан захиргааны үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлж, салбар хоорондын уялдааг хангаж, хамтран ажиллахыг Засгийн газрын гишүүдэд үүрэг болгосугай. | бтг | Хархорум хотын бүтээн байгуулалтын асуудал хариуцсан захиргааны үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлж, салбар хоорондын уялдааг хангаж ажилласан. | | | | Үгүй | |
| 11 | 16 | 2023-2024 оныг Авлигатай тэмцэх жил болгон зарлах тухай | X-1.2. Шугэл үлээх үйл ажиллагааг бүх талаар дэмжих хөдөлгөөн зохион байгуулж, авлигыг үл тэвчих, үл эвлэрэх хандлагыг төлөвшүүлэх, олон нийтийн дэмжлэг авах; | тзуг | “Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай” хууль, “Иргэдийн өргөдөл, гомдлыг шийдвэрлэхтэй холбогдсон зарим арга хэмжээний тухай “ Засгийн газрын 2005 оны 67 дугаар тогтоолын хүрээнд Зам, тээврийн хөгжлийн яам, агентлаг болон холбогдох албан тушаалтанд хандсан өргөдөл, гомдол, мэдээлэл, саналуудыг иргэдээс бичгээр, | | | | Үгүй | |

| | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 11 | 17 | болгон зарлах тухай 2023-02-08 Дугаар 2023_49 | Х-1.3. Төрийн үйлчилгээний хүнд суртал, чирэгдлийг багасгах, иргэд, хувийн хэвшлийн хууль ёсны эрх ашгийг хамгаалах, хамтран ажиллах. | тзуг | “Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай” хууль, “Иргэдийн өргөдөл, гомдлыг шийдвэрлэхтэй холбогдсон зарим арга хэмжээний тухай “ Засгийн газрын 2005 оны 67 дугаар тогтоолын хүрээнд Зам, тээврийн хөгжлийн яам, агентлаг болон холбогдох албан тушаалтанд хандсан өргөдөл, гомдол, мэдээлэл, саналуудыг иргэдээс бичгээр, | | | | Үгүй | |
| 12 | 18 | Хот, хөдөөгийн сэргэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай 2023-02-08 Дугаар 2023_68 | 5. Хот, хөдөөгийн сэргэлтийн зорилтыг хангах зорилгоор харьяа төсөвт байгууллага, төрийн өмчийн үйлдвэрийн газар, төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой компани, түүний салбар, нэгж болон салбарын нийт албан хаагчдын тодорхой хувийг орон нутагт шилжүүлэх ажлыг хэрэгжүүлэхэд зориулан 2023 оны батлагдсан төсвөөс 50.0 (тавин) саяас доошгүй төгрөгийг зарцуулах, цаашид уг зардлыг жил бүрийн улсын төсөвт тусгаж байхыг Засгийн газрын гишүүдэд үүрэг болгосугай. | тзуг | “Шинэ сэргэлтийн бодлого”-ыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд хот хөдөөгийн сэргэлтийн зорилтыг хангах зорилгоор Зам, тээврийн сайдын эрхлэх асуудлын хүрээний харьяа байгууллагуудын хэмжээнд орон нутаг руу шилжүүлэх объект, албан хаагчдын судалгааг гарган 2023 оны 04 дүгээр сарын 21-ний өдрийн 02/1850 тоот албан бичгээр ЗГХЭГ-т албан бичгээр хүргүүлсэн. | | | | Үгүй | |
| 13 | 19 | Түгээмэл тархацтай ашигт малтмал хайх, ашиглах талбайн солбицлыг батлах, эрх олгох тухай 2023-04-12 | 4. Энэ тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Зам, тээврийн хөгжлийн сайд С.Бямбацогт, Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Ж.Ганбаатар нарт тус тус даалгасугай. | азбзг | Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжиж буй "Төв аймгийн Угтаалцайдам, Цээл, Заамар сумдыг холбох 122.4км хатуу хучилттай авто замын барилгын ажил шаардлагатай түгээмэл тархацтай материалыг ашиглах тухай ЗГ-ын 2023 оны 129 дүгээр тогтоолыг үндэслэн орон нутгаас карьерын зөвшөөрлийг гаргуулан гэрээ байгуулж, хэрэгжилтийг хангуулан ажиллаж байна. | | | | Үгүй | |
| 14 | 20 | Түгээмэл тархацтай ашигт малтмал хайх, ашиглах талбайн солбицлыг батлах, эрх олгох тухай 2023-04-12 | 4. Энэ тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Зам, тээврийн хөгжлийн сайд С.Бямбацогт, Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Ж.Ганбаатар нарт даалгасугай. | азбзг | Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар Баян-Өлгий аймагт хийгдэж буй Алтанцөгц сумын 3 км хатуу хучилттай авто замын ажил, Алтай сумын 2.4 км цемент бетон хучилттай авто замын ажил, Улаанхус сумын 24.7 метр урт төмөр бетон гүүрний авто зам, барилга угсралтын ажлыг гүйцэтгэн карьеруудыг нөхөн сэргээж орон нутагт хүлээлгэн өгсөн. | | | | Үгүй | |
| 15 | 21 | Гадаадын хөрөнгө оруулагчдын гомдлыг шийдвэрлэх талаар авах зарим арга хэмжээний тухай 2023-05-03 Дугаар 2023_160 | 1.5. “Нью Улаанбаатар интернэйшнл” ХХК-д дотоодын агаарын тээвэрлэгч “МИАТ” ТӨХК, “Хүннү Эйр” ХХК, “Аэро Монголиа” ХХК-аас төлбөл зохих нэмэгдсэн өртгийн албан татварын хуримтлагдсан өрийг барагдуулах чиглэлээр холбогдох арга хэмжээ авч ажиллахыг Зам, тээврийн хөгжлийн сайд С.Бямбацогт, Сангийн сайд Б.Жавхлан, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар (Б.Цэнгэл)-т | инбзг | Агаарын тээвэрлэгчидтэй тус бүрд нь гэрээ байгуулан 2025 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн дотор багтаан барагдуулахаар тохиролцсон болно. Агаарын тээвэрлэгчид сар бүр тогтмол төлөх төлбөрийн хүснэгт гаргаж хуваарийн дагуу төлбөрөө төлж байгаа болно. | | | | Үгүй | |
| | 22 | | 2. Энэ тогтоолоор өгөгдсөн үүрэг, даалгаврын биелэлт, хэрэгжилтийн явц, тайлан, мэдээг сар бүрийн 23-ны өдрийн дотор Эдийн засаг, хөгжлийн яам, Гадаад харилцааны яаманд тус тус хүргүүлж ажиллахыг холбогдох байгууллага, албан тушаалтанд даалгасугай. | инбзг | Хүргүүлэн ажиллаж байна. | | | | Үгүй | |
| 16 | 23 | Түгээмэл тархацтай ашигт малтмал хайх, ашиглах талбайн солбицлыг батлах, эрх олгох тухай 2023-05-17 | 4. Энэ тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Зам, тээврийн хөгжлийн сайд С.Бямбацогт, Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Ж.Ганбаатар нарт даалгасугай. | азбзг | Өндөрхаан-Норовлин чиглэлийн хатуу хучилттай авто замын үргэлжлэл, эхний 50 км авто замыг 2023 оны 12 дугаар сарын 14-ний Улсын комисс ажиллаж, байнгын ашиглалтад хүлээн авсан бөгөөд нийт зам барилгын ажлын гүйцэтгэл 93.1 хувьтай байна. | | | | Үгүй | |
| 17 | 24 | “Эмээлт эко аж үйлдвэрийн парк”-ийн талаар авах зарим арга хэмжээний тухай 2023-05-24 Дугаар 2023_193 | 3. Орон нутгийн эзэмшлийн авто замын засвар, нөхөн сэргээлт, тохижилтын ажил болон эко аж үйлдвэрийн бүтээн байгуулалтын урсгал зардлыг бага түвшинд байхаар тооцон, хөрсний нөхөн сэргээлт, газар шорооны ажлыг Засгийн газрын гадаад зээлийн хөрөнгөөр санхүүжүүлэхгүй байх чиглэлийг баримталж ажиллахыг Монгол Улсын Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайд Ч.Хүрэлбаатар, Зам, тээврийн хөгжлийн сайд С.Бямбацогт, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Х.Болорчулуун, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч Д.Сумъяабазар нарт тус тус даалгасугай. | азбзг | Тухайн орон нутгийн авто замын эзэмшигч нь Авто замын тухай хуулийн 17.3-д заасны дагуу Нийслэлийн Засаг дарга бөгөөд мөн хуулийн 12.1.4-д заасны дагуу өөрийн эзэмшлийн замын засвар, арчлалт, нөхөн сэргээлтийн ажлыг зохион байгуулах үүрэгтэй. Харин тус яамнаас шаардлагатай тохиолдолд зөвлөмж, арга зүйгээр ханган ажиллах болно. | | | | Үгүй | |

| | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 18 | 25 | Орон нутгийн чиглэлд хуваарьт нислэг үйлдэх зарим арга хэмжээний тухай<br>2023-05-24<br>Дугаар 2023_201 | 1. Монгол Улсын Засгийн газраас 2023-2025 оныг “Монголд зочлох жил” болгон зарласантай холбогдуулан орон нутгийн нислэгийг сэргээн тогтворжуулах, зорчигч тээврийн урсгалыг нэмэгдүүлэх, зорчигчийн тийзийн үнийг хямдруулах зайлшгүй шаардлагыг харгалзан 2023 оны 07 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн Улаанбаатараас орон нутгийн зарим чиглэлд хуваарьт нислэг үйлдэх зохион байгуулалтын арга хэмжээ авахыг Зам, тээврийн хөгжлийн сайд С.Бямбацогт, “МИАТ” ТӨХК-ийн гүйцэтгэх захирал Б.Мөнхтамир нарт даалгасугай. | миат | Үндэсний агаарын тээвэрлэгч МИАТ ТӨХК “Монголд зочлох жил”-ийн хүрээнд аялал жуулчлалыг дэмжих зорилгоор 2008 онд зогсоосон орон нутгийн нислэгээ дахин сэргээж 2023.06.30-ны өдрөөс эхлэн 8 аймгийн чиглэлд долоо хоногийн 2-3 удаагийн давтамжтайгаар тогтмол хуваарьт нислэг үйлдэж эхлэсэн.<br>МИАТ ТӨХК үндэсний агаарын тээвэрлэгчийн хувьд нийгмийн хариуцлагын хүрээнд харьцангуй хямд үнийг санал болгож байна.<br>Тухайлбал: өмнө нь Өлгий, Ховд чиглэлд нислэгийн тийз хоёр талдаа 1,5-1,7 сая байсан бол 810,000-902,000, Улаангом, Улиастай руу 1.3-1.4 сая байсан бол 633,000-852,000 болж 2-2,5 дахин хямдруулсан. Мөн Даланзадгад руу хоёр талдаа 500,000-617,000, | | | | | |
| | | | | инбзг | Үндэсний агаарын тээвэрлэгч МИАТ ТӨХК “Монголд зочлох жил”-ийн хүрээнд аялал жуулчлалыг дэмжих зорилгоор 2008 онд зогсоосон орон нутгийн нислэгээ дахин сэргээж 2023.06.30-ны өдрөөс эхлэн 8 аймгийн чиглэлд долоо хоногийн 2-3 удаагийн давтамжтайгаар тогтмол хуваарьт нислэг үйлдэж эхлэсэн.<br>МИАТ ТӨХК үндэсний агаарын тээвэрлэгчийн хувьд нийгмийн хариуцлагын хүрээнд харьцангуй хямд үнийг санал болгож байна.<br>Тухайлбал: өмнө нь Өлгий, Ховд чиглэлд нислэгийн тийз хоёр талдаа 1,5-1,7 сая байсан бол 810,000-902,000, Улаангом, Улиастай руу 1.3-1.4 сая байсан бол 633,000-852,000 болж 2-2,5 дахин хямдруулсан. Мөн Даланзадгад руу хоёр талдаа 500,000-617,000, Мөрөн рүү 500,000-680,000, Алтай руу 733,000-852,000, Чойбалсан руу 537,000-617,000 төгрөгний тарифаар нислэг үйлдэж байна.<br>МИАТ ТӨХК нь 2024 онд орон нутгийн чиглэлд нислэг үйлдэх 70 хүний суудалтай CRJ-700 маягийн 1 агаарын хөлөг авахаар төлөвлөн агаарын хөлгийг 2024.03.27-ны өдөр хүлээн авсан бөгөөд агаарын хөлгийн нислэгт тэнцэх чадварын гэрчилгээжих хүрээнд нислэг техникийн бэлтгэл ажил, бичиг баримтын бүрдүүлэлтийн хийж гүйцэтгэн ИНЕГ-т шалгуулж, нислэгийн зөвшөөрөл авсан.<br>Уг агаарын хөлгөөр 2024.04.28-ны өдөр эхний нислэгийг УБ-Ховд-УБ чиглэлд үйлдсэн.<br>МИАТ ТӨХК ийнхүү Монголд зочлох жил болон Бүсчилсэн хөгжлийг дэмжих бүтээн байгуулалтын жилийн хүрээнд орон нутгийн 8 | | | | Үгүй | |
| 19 | 26 | Авто замын засвар арчлалтын компаниудыг өөрчлөн зохион байгуулах зарим арга хэмжээний тухай<br>2023-06-07<br>Дугаар 2023_220 | 3. Засгийн газрын гадаад зээллэгийн эх үүсвэрээр бий болсон хөрөнгө, түүнтэй холбоотой дамжуулан зээлийн өр төлбөрийг хавсралтад заасан компаниудтай тооцоо нийлж баталгаажуулах, энэхүү хөрөнгө, өр төлбөр болон бусад өр төлбөр, авлага, үндсэн болон эргэлтийн хөрөнгийг холбогдох хууль, журамд заасны дагуу “Авто замын засвар арчлалтын нэгтгэл” ТӨХК-ийн санхүүгийн тайланд шилжүүлэх арга хэмжээ авах, авлага, өр төлбөр, хөрөнгийг хүлээн авсантай холбогдуулан тооцоо нийлж баталгаажуулах, компанийн дүрэм, бүтцийг батлах, зардал бууруулах, үр ашгийг нэмэгдүүлэх чиглэлээр удирдлага, зохион байгуулалтын зохих арга хэмжээ авч ажиллахыг Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Д.Амарбаясгалан, Зам, тээврийн хөгжлийн сайд С.Бямбацогт, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар (Б.Цэнгэл)-т тус тус үүрэг болгосугай. | азбзг | 2009 онд Кувейтын сангийн санхүүжилттэй 5.5 сая төгрөгийн үндсэн хөрөнгийг Зам тээвэр, хот байгуулалтын сайдын 2009 оны 166 дугаар тушаал, Төрийн өмчийн хорооны 2009 оны 9 дүгээр сарын 15-ны өдрийн 3/1538 тоот албан бичгийн дагуу орон нутгийн 20 авто замын засвар арчлалтын компаниуд хүлээн авч нягтлан бодох бүртгэлд тусгахдаа 1 компани 0.3 сая төгрөгөөр дүрмийн сангаар нэмэгдүүлж бүртгэсэн, 15 компани нь урт хугацаат өр төлбөрөөр бүртгэсэн байв. Энэхүү санхүүгийн буруу бүртгэснийг Засгийн газрын 2009 оны 9 дүгээр сарын 16-ны өдрийн 284 дүгээр тогтоол, Төрийн өмчийн хорооны 2009 оны 10 дугаар сарын 02 өдрийн 3/1699 тоот албан бичиг зэрэг холбогдох баримт бичгүүдийг үндэслэн 2024 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд залруулга хийлгэж, 2025 оны 6 дугаар сарын 23-ны өдрийн байдлаар 3.4 сая төгрөгийн урт хугацаат өр төлбөрийн үлдэгдэл байна. Үндсэн хөрөнгийн хувьд бодит үлдэгдэлгүй, данснаас хасагдаж актлагдсан байна.<br>20 компанийн хөрөнгө, өр төлбөр болон бусад өр төлбөр, авлага, үндсэн болон эргэлтийн хөрөнгийг 2024 оны жилийн эцсийн аудитлагдсан санхүүгийн тайлангийн дүнгээр холбогдох хууль, журмын дагуу нэгтгээд байна.Тухайлбал: 13,752,243,999 төгрөг 50 мөнгөний эргэлтийн хөрөнгө, 26,051,223,457 төгрөг 01 мөнгөний эргэлтийн бус хөрөнгө, 13,179,676,178.40 төгрөг 40 мөнгөний нийт өр төлбөр, 26,623,791,348 төгрөг 12 мөнгө бүхий эзэмшигчдийн өмчийг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын хурлаар танилцуулан шийдвэрлүүлэх арга хэмжээ авахаар ажиллаж байна.<br>Мөн ТӨБЗГ-ын 2024 оны 108 дугаар тогтоолоор Төрийн өмчийн | | | | Үгүй | |

| | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | 27 | | 4. Энэ тогтоол гарсантай холбогдуулан Улсын Их Хурлын 2022 оны 04 дүгээр сарын 29-ний өдрийн 16 дугаар тогтоолоор баталсан "Төрийн өмчит хуулийн этгээдийн хувьцааг 2022-2023 онд биржээр олон нийтэд нээлттэй худалдах үндсэн чиглэл"-д өөрчлөлт оруулах талаар саналаа боловсруулж, танилцуулахыг Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Д.Амарбаясгалан, Зам, тээврийн хөгжлийн сайд С.Бямбацогт, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар (Б.Цэнгэл)-т тус тус даалгасугай. | азбзг | Тус тогтоолын хавсралтаар батлагдсан "Төрийн өмчит хуулийн этгээдийн хувьцааг 2022-2023 онд биржээр олон нийтэд нээлттэй худалдах үндсэн чиглэл"-ийн 4.1.6-4.1.25-д тусгагдсан авто замын засвар арчлалтын нийт 20 төрийн өмчит хувьцаат компанийг хасч, 4.1.6-д "Авто замын засвар арчлалтын нэгтгэл" төрийн өмчит хувьцаат компани болгон өөрчлөлт оруулан тусгах. | | | | Үгүй | |
| 20 | 28 | Макро эдийн засгийн тогтвортой байдлыг хангах чиглэлээр авах зарим арга хэмжээний тухай 2023-06-21 Дугаар 2023_233 | 8. Улаанбаатар хотын авто замын түгжрэлийг бууруулахад радио давтамжаар таних систем (RFID)-ийг 2023 оны 3 дугаар улиралд багтаан ашиглалтад оруулахыг Монгол Улсын сайд, Нийслэл Улаанбаатар хотын авто замын түгжрэлийг бууруулах Үндэсний хорооны дарга Ж.Сүхбаатар, Зам, тээврийн хөгжлийн сайд С.Бямбацогт нарт даалгасугай. | атбзг | Нийслэлийн Засаг даргын тамгын газартай хамтран хэрэгжүүлж байгаа бөгөөд Улаанбаатар хотын хэмжээнд 161 уулзварт 455 уншигч төхөөрөмжийг суурилуулж, улсын хэмжээнд 2025 оны эхний хагас жилийн байдлаар 465,000 тээврийн хэрэгсэлд RFID tag суурилуулах ажлыг зохион байгуулаад байна. | | | | Үгүй | |
| | 29 | | 12. Энэ тогтоолоор өгөгдсөн үүрэг даалгаврын биелэлт, хэрэгжилтийн явц, тайлан, мэдээг сар тутам Эдийн засаг, хөгжлийн яаманд хүргүүлж ажиллахыг холбогдох байгууллага, албан тушаалтанд даалгасугай. | атбзг | Нийслэлийн Засаг даргын тамгын газартай хамтран хэрэгжүүлж байгаа бөгөөд Улаанбаатар хотын хэмжээнд 161 уулзварт 455 уншигч төхөөрөмжийг суурилуулж, улсын хэмжээнд 2025 оны эхний хагас жилийн байдлаар 465,000 тээврийн хэрэгсэлд RFID tag суурилуулах ажлыг зохион байгуулаад байна. | | | | Үгүй | |
| 21 | 30 | "Журам батлах тухай" /Зөвшөөрлийн нэгдсэн сангийн мэдээлэл түүнийг бүрдүүлэх, уг санд зөвшөөрлийг бүртгэх, лавлагаа мэдээлэл өгөх/ Засгийн газрын тогтоол | 1. 2.Журмын хэрэгжилтийг зохион байгуулж, ажиллахыг зөвшөөрөл олгох эрх бүхий этгээдэд үүрэг болгосугай. | мтх | "Зөвшөөрлийн нэгдсэн сангийн мэдээлэл, түүнийг бүрдүүлэх, уг санд зөвшөөрлийг бүртгэх, лавлагаа, мэдээлэл өгөх журам"-ын дагуу e-Business.mn портал сайт руу мэдээлэл дамжуулах холболтыг хийхээр ЭЗХЯ-тай хамтран ажиллаж байна. ЭЗХЯ, И-Монгол академийн холбогдох хүмүүстэй уулзалт хийж, e-Business.mn портал сайтад холбогдох салбаруудын тусгай зөвшөөрлүүдийг оруулж хөгжүүлэлт хийсэн. | | | | Үгүй | |
| 22 | 31 | Журам шинэчлэн батлах тухай 2023-07-19 Дугаар 2023_278 | 2. Энэ журмыг хэрэгжүүлж ажиллахыг бүх шатны төсвийн захирагч нарт, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Сангийн сайд Б.Жавхланд тус тус үүрэг болгосугай.(1."Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам) | сх | 1. Хуулийн хэрэгжилтийг ханган ажиллаж 2024 оны Зам, тээврийн сайдын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээг тус журмын дагуу 2025 оны 01 дүгээр сарын 15 өдөрт багтааж зохих маягтын дагуу тайлагнасан. 2. Хуулийн хэрэгжилтийг ханган ажиллаж 2025 он Зам, тээврийн сайдын төсвийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааны | | | | Үгүй | |
| 23 | 32 | Төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээд байгуулах тухай 2023-08-16 Дугаар 2023_300 | 3. "Сайншанд-Баруун-Урт-Хөөт төмөр зам" ХХК-д хөрөнгө оруулж, хамтран ажиллах сонирхол бүхий гадаад, дотоодын хуулийн этгээдийг сонгох ажлыг зохион байгуулахыг Зам, тээврийн хөгжлийн сайд С.Бямбацогт, "Монголын төмөр зам" ТӨХК (Б.Отгонсүх)-д даалгасугай. | тзг | | | | | | |
| | | | | мтз | Засгийн газрын 300 дугаар тогтоолын дагуу Сайншанд-Баруун-Урт-Хөөт чиглэлийн төмөр замын төсөлд хөрөнгө оруулж, хамтран ажиллах сонирхол бүхий гадаад, дотоодын хуулийн этгээдийг сонгох бэлтгэл ажлыг зохион байгуулах ажлын хэсгийг "Монголын төмөр зам" ТӨХК-ийн Гүйцэтгэх захирлын 2023 оны 09 дүгээр сарын 11-ний өдрийн А/131 тоот тушаалаар байгуулсан. Ажлын хэсэг хөрөнгө оруулагчид тавигдах шаардлагууд, бүрдүүлэх баримт бичиг зэрэг бусад мэдээллийг багтаасан "Хөрөнгө оруулагч сонголтын баримт бичиг"-ийн төслийг боловсруулан гишүүдийн саналыг тусгаж эцэслэсэн.<br>"Хөрөнгө оруулагч сонголтын баримт бичиг"-ийн төслийг санал авахаар ЗТХ-ийн сайдад 2023 оны 9-р сарын 21-ны өдрийн 01/1531 | | | | Үгүй | |
| | 33 | | 4. Энэ тогтоолын 1-д заасан компанитай холбогдох хууль тогтоомжид заасны дагуу шууд гэрээ байгуулах арга хэмжээ авахыг Зам, тээврийн хөгжлийн сайд С.Бямбацогт, Төрийн худалдан авах ажиллагааны газар (Ц.Батзул)-т даалгасугай. | тзг | ТХААГ-ын даргын 2023 оны 10 дугаар сарын 10-ний өдрийн А/276 дугаар тушаалаар ажлын хэсэг байгуулагдсан. Тус ажлын хэсэг хуралдаж сонгон шалгаруулах баримт бичиг боловсруулахаар ажиллаж байна. Сонгон шалгаруулалт дууссны дараа Концессын шууд гэрээ байгуулах эсэх талаар дүгнэлт гаргах ажлын хэсгийг мөн ТХААГ-ын даргын 2023 оны 09 дүгээр сарын 18-ны өдрийн А/262 дугаар тушаалаар ажлын хэсэг байгуулагдсан.Ажлын хэсэг дараах ажлыг хийж гүйцэтгэв. Үүнд:<br>1. Хөрөнгө оруулагчид тавигдах шаардлагууд, бүрдүүлэх баримт бичиг зэрэг бусад мэдээллийг багтаасан "Хөрөнгө оруулагч сонголтын баримт бичиг"-ийн төслийг боловсруулан гишүүдийн саналыг тусгаж эцэслэсэн.<br>2. "Хөрөнгө оруулагч сонголтын баримт бичиг"-ийн төслийг санал авахаар ЗТХ-ийн сайдад 2023 оны 9-р сарын 21-ны өдрийн 01/1531 тоот албан бичгээр хүргүүлсэн. | | | | Үгүй | |

| | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | 34 | | 5. Сайншанд-Баруун-Урт-Хөөт чиглэлийн төмөр замын төслийн хэрэгжилтийг зохион байгуулж, явц байдлыг Засгийн газрын хуралдаанд улирал тутам танилцуулж ажиллахыг Зам, тээврийн хөгжлийн сайд С.Бямбацогтод үүрэг болгосугай. | тзг | Тус чиглэлийн төмөр замын ТЭЗҮ-ийг БНСУ-ын Газар, дэд бүтэц, тээврийн яамны зүгээс энэ төслийг буцалтгүй тусламжийн хүрээнд хэрэгжүүлж БНСУ-ын хэд хэдэн байгууллагын төлөөллөөс бүрдсэн Судалгааны баг боловсруулсан. Судалгааны багт БНСУ-ын Тээврийн Судалгааны Хүрээлэн (KOTI), Юшин Инженеринг компани (Yooshin Engineering), БНСУ-ын Үндэсний Төмөр Замын Корпораци (KORAIL), БНСУ-ын Гео шинжлэх ухаан, эрдэс баялгийн нөөцийн хүрээлэн (KIGAM) гэсэн талуудаас бүрдсэн консорциум ажилласан. “Монголын төмөр зам” ТӨХК нь “Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай” хууль, Засгийн газрын 2023 оны 404 дүгээр тогтоолоор батлагдсан “Түншлэлээр хэрэгжүүлэх төслийн бүрэн шинжилгээ хийх журам” зэрэгт нийцүүлж хэрэгжүүлэх зорилгоор урьдчилсан | | | | Үгүй | |
| 24 | 35 | Төсөл, хөтөлбөрийн жагсаалт батлах тухай<br>2023-08-23<br>Дугаар 2023_323 | 2. Энэ тогтоолын хавсралтад заасан төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар Азийн хөгжлийн банктай тохиролцож, холбогдох гэрээ, хэлэлцээрийг байгуулах арга хэмжээ авахыг Сангийн сайд Б.Жавхланд, төсөл, хөтөлбөрийг цаг хугацаанд нь үр дүнтэй хэрэгжүүлэх арга хэмжээ авч ажиллахыг Засгийн газрын холбогдох гишүүдэд тус тус даалгасугай. | азбзг | Тогтоолын хавсалтад заасан "Бүс нутгийн авто зам хөгжүүлэх засвар арчлалтын төсөл (III үе шат)"-ийн зээлийн хэлэлцээрийг Азийн хөгжлийн банктай байгуулж УИХ-аар соёрхон батлуулсан. Зээлийн хэлэлцээрийн дагуу төслийн зөвлөх болон гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах ажил ЗТЯам болон Төрийн худалдан авах ажиллагааны газарт явагдаж байна. | | | | Үгүй | |
| 25 | 36 | Иргэний эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлэхэд чиглэсэн зарим арга хэмжээний тухай<br>2023-08-30<br>Дугаар 2023_321 | 2. Иргэний эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлэх арга хэмжээг харьяалах салбар, нутаг дэвсгэртээ зохион байгуулж, үр дүнг тооцож ажиллахыг Засгийн газрын гишүүд, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт үүрэг болгож, шаардагдах зардлыг төсвийн ерөнхийлөн захирагч нарын саналыг харгалзан улсын нэгдсэн төсвийн төсөлд тусган, хэрэгжүүлэх арга хэмжээ авахыг Сангийн сайд Б.Жавхланд даалгасугай. | тзүг | ЭМС-ын А/75, А/09, А/79, А/34 тоот тушаалаар батлагдсан Иргэний эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлэх арга хэмжээг УБТЗ-ын Төв эмнэлэг 2024 оны 03 дугаар сарын 20нд 3 зорилт 7 зүйл бүхий төлөвлөгөө баталсан. Тус төлөвлөгөөний 1-р зорилтын хүрээнд Иргэний эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлэх салбар хоорондын уялдаа холбоог сайжруулах талаар тусгаж УБТЗ-ын эрсдэлт бүлгийн ажилчдад төв эмнэлгийн биеийн тамирын арга зүйч, хоол зүйч, эрүүл мэндийн нийгмийн ажилтан нар хамтран Зорчигчийн вагон депо, Зорчигч үйлчилгээний төв, УБТЗ-ын Сайншанд татах хэсэг, Солонго цэцэрлэгийн нийт 1500 ажилтанд "Эрүүл хооллолт, эрүүл мэндийн зан үйл, Дасгал хөдөлгөөн хийхийн ач холбогдол" сэдвээр сургалт орж зөвлөгөө өгсөн. Мөн Төв эмнэлгийн биеийн тамирын өрөөнд нуруунь суултай, таргалалттай 23 иргэн тогтмол ирж тохирсон дасгал хөдөлгөөн хийж байна.<br>Зорилт 2-ийн хүрээнд эрүүл мэндийг дэмжих орчин бүрдүүлэх талаар тусгаж Замын даргын 2019 оны А11 тоот тушаалын дагуу Эрүүл мэндийг дэмжигч байгууллага шалгаруулах болзолт уралдааныг жил бүр уламжлан зохион байгуулахтай холбогдуулан 2024 онд тус уралдааныг таниулах зорилгоор 2 удаагийн постер хийж цахимаар түгээж 4-р улиралд материал хүлээн авсан, үнэлгээний шатанд явагдаж байна. Зорилт 3-ийн хүрээнд ажилчдын эрүүл мэндийг дэмжих орчин бүрдүүлэх талаар тусгаж 2023 оны 12 дугаар сараас эхлэн УБТЗ-ын Төв эмнэлгийн 58 ажилтан өглөө 07 цагт, өдөр 11 цагуудад 2 ээлжинд хуваагдан тогтмол иогоор | | | | Үгүй | |
| 26 | 37 | Түгээмэл тархацтай ашигт малтмал хайх, ашиглах талбайн солбицлыг батлах, эрх олгох тухай<br>2023-09-20<br>Дугаар 2023_351 | 3. Түгээмэл тархацтай ашигт малтмал хайх, ашиглах болон зам, замын байгууламж барих ажлын явцад соёлын биет өв илрэх тохиолдолд холбогдох эрх бүхий байгууллагад нэн даруй мэдээлэх, ажил дууссаны дараа түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласан талбайг холбогдох стандарт, нормын дагуу нөхөн сэргээж, орон нутгийн эрх бүхий байгууллагад зохих ёсоор хүлээлгэн өгөхийг ажил гүйцэтгэж байгаа хуулийн этгээдэд, үйл ажиллагаанд хяналт тавьж ажиллахыг Зам, тээврийн хөгжлийн сайд С.Бямбацогт, Байгаль орчин, аялал жуулчлалын сайд Б.Бат-Эрдэнэ, Соёлын сайд Ч.Номин, Сүхбаатар аймгийн Засаг дарга М.Идэрбат нарт үүрэг болгосугай. | азбзг | Бичигт боомтыг хатуу хучилттай авто замаар холбох зорилтын хүрээнд Эрээнтолгой нүүрсний уурхайгаас Бичигтийн боомт хүртэлх 110.3км тусгай зориулалтын авто зам, Бичигт боомтын авто зам, гадна инженерийн шугам сүлжээний барилга угсралтын ажлын явцад хяналт тавин ажиллаж байгаа ба соёлын биет өв, олдвор олдоогүй байна. Илэрсэн тохиолдолд холбогдох байгууллагад нэн даруй мэдээлж, холбогдох арга хэмжээг хууль тогтоомжийн хүрээнд авах болно. Зам барилгын ажил дуусахад ашиглаж буй Түгээмэл тархацтай ашигт малтмалын карьеруудыг бүрэн нөхөн сэргээлгэж, орон нутагт хүлээлгэн өгнө. | | | | Үгүй | |
| | 38 | | 4. Энэ тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Зам, тээврийн хөгжлийн сайд С.Бямбацогт, Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Ж.Ганбаатар нарт даалгасугай. | азбзг | Тогтоолын хэрэгжилтэд Зам, тээврийн яамнаас байнгын хяналт тавин ажиллаж байна. | | | | Үгүй | |

| | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 27 | 39 | Жагсаалт батлах тухай<br>2023-11-22<br>Дугаар 2023_409 | 4.. Худалдан авах ажиллагаар Төрийн худалдан авах ажиллагааны цахим систем (www.tender.gov.mn)-ээр зохион байгуулж, Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуулиар батлагдсан хуулийн дугаар, төсөл, арга хэмжээний нэр, хүчин чадал, байршил, төслийн код (“УТ” код)-ыг батлагдсан хэлбэрээр худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд тусгаж, тендерийн урилга, үр дүнг тухай бүр цахим системд нийтэлж байхыг төсвийн ерөнхийлөн захирагч, Төрийн худалдан авах ажиллагааны газарт тус тус даалгасугай. | сх | **Холбогдох журмын дагуу худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг боловсруулан батлууж, Төрийн худалдан авах ажиллагааны цахим системд байршуулсан. Төсөл, арга хэмжээнүүдийн худалдан авах ажиллагааг цахим системээр холбогдох хууль, журмын дагуу зохион байгуулж урилга, үр дүнг тухай бүрт нь нийтлэсэн.** | | | | Үгүй | |
| | 40 | | 5. Тогтоолын хавсралтад заасан төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг холбогдох хууль тогтоомжийн дагуу ашиг сонирхлын зөрчил, авлигаас ангид байх зарчмыг баримтлан шуурхай зохион байгуулж ажиллахыг Төрийн худалдан авах ажиллагааны газар, төсвийн ерөнхийлөн захирагч нарт, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Монгол Улсын Шадар сайд С.Амарсайханд тус тус үүрэг болгосугай. | сх | **1. Тогтоолын хавсралтаар Төрийн худалдан авах ажиллагааны газарт болон аймаг, нийслэлийн засаг даргуудад хэрэгжүүлэхээр баталсан төсөл, арга хэмжээнүүдийн худалдан авах ажиллагаанд шаардагдах зураг төсөв бусад холбогдох материалуудыг шуурхай хүргүүлж худалдан авах ажиллагааг зохион байгуулсан.** | | | | Үгүй | |
| 28 | 41 | Нийслэл Улаанбаатар хотод Их багтаамжийн нийтийн тээврийн хэрэгсэл “Метро” байгуулах тухай (2023 оны 484-р тогтоолоор өөрчлөлт орсон)<br>2023-11-22<br>Дугаар 2023_411 | 8. Нийслэл Улаанбаатар хотын авто замын түгжрэлийг бууруулах чиглэлээр хэрэгжүүлж байгаа бусад авто зам, замын байгууламж, олон төрөлт нийтийн тээвэр, хөдөлгөөн зохион байгуулалттай холбоотой төсөл, арга хэмжээ хоорондын уялдаа холбоог хангах, тэдгээрийг хот төлөвлөлтийн бодлого, төлөвлөгөөнд нийцүүлэн, үр нөлөө, ач холбогдлоор нь эрэмбэлэх, санхүүжилтийн эх үүсвэрийг тодорхойлж, суурь судалгаа тооцооллыг хийж, уялдуулан зохицуулах, тогтвортой, үр дүнтэй, шуурхай удирдах зохион байгуулалтын арга хэмжээ авч ажиллахыг Монгол Улсын сайд, Нийслэл Улаанбаатар хотын авто замын түгжрэлийг бууруулах Үндэсний хорооны дарга Б.Дэлгэрсайхан, Зам, тээврийн хөгжлийн сайд С.Бямбацогт, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагч Х.Нямбаатар нарт тус тус үүрэг болгосугай. | атбзг | Нийслэлийн Засаг дарга бөгөөд УБ хотын захирагчийн2025 оны 04 дүгээр сарын 16-ны өдрийн А/503 дугаар захирамжаар байгуулагдсан "Нийслэл Улаанбаатар хотод их багтаамжийн нийтийн тээврийн хэрэгсэл "Метро"-г барьж байгуулах ажлын бүтээн байгуулалтын ажлын гүйцэтгэгч сонгон шалгаруулах нээлттэй тендер шалгаруулалтын 2 дугаар үе шатны тендерийн баримт бичиг, техникийн тодорхойлолтод санал зөвлөмж өгөх, мэргэжил арга зүйн туслалцаа үзүүлэх" үүрэг бүхий Ажлын хэсэгт тус яамны АЗБЗГ-ын ахлах шинжээч Д.Загдраднаа, АТБЗГ-ын ахлах мэргэжилтэн З.Чүнсэрээ, ТЗДТБЗГ-ын ахлах мэргэжилтэн Б.Батнасан нар ажиллаж 2025 оны 04 дүгээр сарын 22, 25-ны өдрүүдэд зохион байгуулагдсан хуралд оролцон санал, зөвлөмжөө тусган ажилласан. | | | | Үгүй | |
| | 42 | | 9. Энэ тогтоол гарсантай холбогдуулан нарийн мэргэжлийн зайлшгүй шаардлагатай ажилтан, албан хаагчийг түр хугацаагаар шилжүүлэн ажиллуулах, төслийн хэрэгжилтийг хангахтай холбоотой мэдээ, мэдээллийг цаг алдалгүй шуурхай гаргаж өгөх, судалгаа тооцоолол хийх зэрэг үйл ажиллагаанд эрхэлсэн салбар, чиглэлд хамаарах асуудлаар бүхий л талын туслалцаа, дэмжлэг үзүүлж, мэргэжил, арга зүйн зөвлөгөө, зөвлөмжөөр хангаж ажиллахыг Засгийн газрын гишүүд, Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлагийн дарга, төрийн болон орон нутгийн өмчийн хуулийн этгээдийн удирдлагуудад тус тус үүрэг болгосугай. | тзг | | | | | Үгүй | |
| 29 | 43 | Журам, жагсаалт, үнийн дүн батлах тухай<br>2023-12-13<br>Дугаар 2023_445<br>"Гадаадын жуулчны хувийн хэрэгцээнд зориулж худалдан авсан бараанд төлсөн нэмэгдсэн өртгийн албан татварын буцаан олголтын төлбөрийн | 3.. 3.Энэ тогтоолыг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлж ажиллахыг Гадаад харилцааны сайд Б.Батцэцэг, Хууль зүй, дотоод хэргийн сайд Б.Энхбаяр, Байгаль орчин, аялал жуулчлалын сайд Б.Бат-Эрдэнэ, Зам, тээврийн хөгжлийн сайд С.Бямбацогт нарт, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Сангийн сайд Б.Жавхланд тус тус үүрэг болгосугай. | миат | "МИАТ" ТӨХК нь "Гадаадын жуулчны хувийн хэрэгцээнд зориулж худалдан авсан бараанд төлсөн нэмэгдсэн өртгийн албан татварын буцаан олголтын төлбөрийн баримтыг бүртгэх, түүнд хяналт тавих журам"-ын дагуу тус компанийн орон нутгийн нислэгээр үйлчлүүлсэн гадаадын иргэнд нэмэгдсэн өртгийн албан татварын 10 хувийн буцаан олголтын төлбөрийн баримтыг тухай бүр нь цахим хаягаар нь хүргүүлэн тус журмыг бүрэн хэрэгжүүлэн ажиллаж байна. | | | | Үгүй | |
| 30 | 44 | Улсын төсвийн хөрөнгө оруулалтын талаар авах зарим арга хэмжээний тухай<br>2023-12-13<br>Дугаар 2023_456 | 1.3.. 1.3.Төсөл, арга хэмжээ, барилга байгууламжийн гүйцэтгэлд хяналт тавьж, баталгаажуулсны үндсэн дээр 2024 оны 10 дугаар сарын 30-ны өдрийн дотор энэ тогтоолын 1.2-т заасны дагуу барьцаа хөрөнгийн дансанд байршуулсан олгогдоогүй санхүүжилтийн үлдэгдлээс бодит гүйцэтгэлээр санхүүжүүлэх. | сх | Барьцаа хөрөнгийн дансанд байршуулсан олгогдоогүй санхүүжилтийн үлдэгдлээс гүйцэтгэлээр 4.4 тэрбум төгрөгийг санхүүжүүлсэн. | | | | Үгүй | |

| | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 103 | 160 | Хөдөө аж ахуйн салбарын 2025-2026 оны өвөлжилт, хаваржилтын бэлтгэл хангах зарим арга хэмжээний тухай 2025-08-20 Дугаар 2025_56 | 2.3.. мэргэжлийн байгууллагын дүгнэлтэд үндэслэн ган, зудын зураглалыг нарийвчлан гаргах, эрсдэлийн үнэлгээ хийх аргачлалыг бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалд нийцүүлэн шинэчлэн батлахыг Монгол Улсын Шадар сайд С.Амарсайхан, Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайд Б.Батбаатар, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Ж.Энхбаяр, Онцгой байдлын ерөнхий газар (Г.Ариунбуян)-т; | ТЗУГ | | | | | Үгүй | |
| | 161 | | 3.. Хөдөө аж ахуйн салбарын өвөлжилт, хаваржилтын бэлтгэл хангах, хүндрэл багатай даван туулахад шаардлагатай санхүүжилтийг батлагдсан төсөвтөө багтаан шийдвэрлэхийг Засгийн газрын гишүүд, Засгийн газрын агентлагийн дарга болон аймаг, нийслэлийн Засаг дарга нарт тус тус үүрэг болгосугай. | ТЗУГ | | | | | Үгүй | |
| **Ерөнхий сайдын захирамж** | | | | | | | | | | |
| 104 | 162 | Ажлын хэсэг байгуулах тухай 2023-06-12 Дугаар 2023_108 | 2. Ногоон технологи, ногоон эдийн засгийг дэмжих зорилгоор цахилгаан автомашины хэрэглээг нэмэгдүүлэх, цахилгаан машиныг цэнэглэх төвүүдийг байгуулах асуудлыг нарийвчлан судалж, шийдлийн төсөл танилцуулах, батлуулах, хэрэгжүүлэх ажиллагааг удирдлага зохион байгуулалтаар хангаж ажиллах Ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай:<br>Ажлын хэсгийн үйл ажиллагааны явц, дүнг тухай бүр нь танилцуулж ажиллахыг Ажлын хэсэг (С.Бямбацогт)-т даалгасугай. | АТБЗГ | Монгол Улсад 2024-2026 онд "Цахилгаан автомашины хэрэглээг нэмэгдүүлэх арга хэмжээний төлөвлөгөө"-г Зам, тээврийн хөгжлийн сайд /хуучнаар/ Сангийн сайд, Байгаль орчин, аялал жуулчлалын сайд /хуучнаар/, Эрчим хүчний сайд хамтарч баталж, 21 аймгийн Засаг дарга, холбогдох байгууллагуудад хэрэгжүүлж ажиллах, үүрэг чиглэлийг хүргүүлсэн. Төлөвлөгөөний хэрэгжилтэд хяналт тавьж ажиллаж байна. Монгол Улс дахь цахилгаан тээврийн хэрэгслийн хэрэглээг нэмэгдүүлэх судалгаа, зөвлөмж, замын зураглалыг Дэлхийн банкаар хоёр жилийн хугацаанд хийлгэж 2025 оны 3 дугаар сард хүлээж авсан. Цахилгаан автомашины хэрэглээ, цэнэглэх станц, дэд бүтцийн хүртээмжийг нэмэгдүүлэх, орчны бохирдолд автотээврийн хэрэгслээс үүдэлтэй сөрөг нөлөөг багасгах, авто замын дагуух үйлчилгээний байгууламж байгуулах “NEXUS, Ногоон шийдэл” төр, хувийн хэвшлийн түншлэл EVENT арга хэмжээг 2025.04.03-ны “Эм.Эм.Эс” ХХК-тай хамтран зохион байгуулав. Уг арга хэмжээнээс орон нутагт 44 байршилд цахилгаан автомашин цэнэглэх станц, авто замын дагуух үйлчилгээний байгууламж | | | | Үгүй | |

| | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 105 | 163 | Ажлын хэсэг шинэчлэн байгуулах тухай<br>2023-06-16<br>Дугаар 2023_111 | 2. Монгол Улсад олон улсын хуурай боомт байгуулах эрх зүйн орчныг бүрдүүлэх, хөрөнгө оруулалтын асуудлыг судалж санал боловсруулах, гадаад улс, олон улсын байгууллагын дэмжлэг авч, төр, хувийн хэвшлийн түншлэлийг хангах үүрэг бүхий Ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэйгээр шинэчлэн байгуулсугай:<br><br>Ажлын хэсгийн үйл ажиллагааны төлөвлөгөөг баталж, удирдлага, зохион байгуулалтаар хангаж ажиллахыг Ажлын хэсгийн дарга (С.Бямбацогт)-д даалгасугай. | ТЗДТБЗГ | Ажлын хэсгийн батлагдсан төлөвлөгөөний биелэлтийг боловсруулж, үнэлгээ хийсэн ба Монгол Улсын Ерөнхий сайдын 2023 оны 111 дүгээр захирамжийн хүрээнд Далайн захиргааны хийж гүйцэтгэх ажлын төлөвлөгөө 2025 оны 03 дугаар сарын 19-ний өдөр боловсруулж батлуулсан болно. Батлагдсан төлөвлөгөөний дагуу дараах ажлуудыг хийж гүйцэтгэв. Үүнд:<br>-НҮБ-ын АНДЭЗНК-ын "Хуурай боомтын тухай" Засгийн газар хоорондын хэлэлцээрийн 1 дүгээр хавсралтад нэмэлт өөрчлөлт орсныг хянан баталгаажуулахаар ЗТЯ-нд хүргүүлсний дагуу ЗТЯ-наас ХЗДХЯ, ГХЯ-нд хүргүүлж, холбогдох хариу хүлээгдэж байна.<br>-Хуурай боомтын хөрөнгө оруулалт татах ажлын хүрээнд Дэлхийн банкны санхүүжилтээр "Замын-Үүд хуурай боомтын ТЭЗҮ боловсруулах тухай" хурал ЗТЯ-нд 2025 оны 02 дугаар сарын 12-ны өдөр зохион байгуулагдсан ба холбогдох судалгаа, авч хэрэгжүүлсэн ажлын тухай танилцуулгыг хийж ажилласан.<br>-НҮБ-ын АНДЭЗНК-оос 2025 оны 03 дугаар сарын 26-27-ны өдрүүд Тайланд Улсын Бангкок хотноо зохион байгуулагдсан "Хуурай боомтын үйл ажиллагаа, логистик болон олон төрөлт тээврийн үйлчилгээнд оролцогч талуудын форум"-д илтгэл тавьж, хууль эрх зүйн орчны талаар туршлага судлах, техникийн туслалцаа авах талаарх хүсэлтийг гаргаж ажиллав.<br>-НҮБ-ын АНДЭЗНК-оос эрхлэн гаргасан Төр хувийн хэвшлийн түншлэлийн амжилттай хэрэгжсэн олон улсын жишээ, туршлагыг орчуулсан болно.<br>-Хуурай боомт байгуулах байршил болон газрын асуудлаар Дорноговь аймаг, Говьсүмбэр аймаг болон "Хүннү смарт хот"-ын холбогдох албаны хүмүүстэй уулзаж хамтран ажиллаж байна.<br>-Олон улсын чанартай хуурай боомтын үндэсний стандарт | | | | Үгүй | |
| 106 | 164 | Ажил хариуцуулах тухай<br>2024-03-14<br>Дугаар 2024_34 | 3.. Үндэсний зөвлөл, Үндэсний хороо, зөвлөлийн хуралдаанаар хэлэлцэн шийдвэрлэсэн асуудлын хэрэгжилтийг зохион байгуулж, хуралдааны тэмдэглэл, шийдвэрийн төслийг хуралдаан зохион байгуулснаас хойш 7 хоногийн дотор, үйл ажиллагааны талаарх тайлан, мэдээг улирал бүр Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт ирүүлэхийг Үндэсний зөвлөл, хорооны нарийн бичгийн дарга нарт үүрэг болгосугай. | АТБЗГ | Агаарын тээврийн хялбаршуулах үйл ажиллагааг зохицуулах зөвлөл, Иргэний нисэхийн аюулгүй байдлын зөвлөлийн үйл ажиллагааны эхний хагас жилийн тайланг ирүүлэх тухай албан бичгийг Иргэний нисэхийн ерөнхий газарт хүргүүлэв. 2025.06.12 09/2775 | | | | Үгүй | |
| 107 | 165 | Ажлын хэсэг байгуулах тухай /Агаарын навигацийн дэд бүтэц, техник, тоног төхөөрөмжийн хангалт, ашиглалтын байдлыг газар дээр нь судалж, санал, дүгнэлт гаргах / | 2.. Энэ захирамжийн 1 дүгээр зүйлд заасан ажлын үр дүн, санал, дүгнэлтийг 2025 оны 08 дугаар сарын 25-ны өдрийн дотор Ерөнхий сайдад танилцуулахыг Ажлын хэсэг (С.Батболд)-т даалгасугай.<br>"Агаарын навигацийн дэд бүтэц, техник, тоног төхөөрөмжийн хангалт, ашиглалтын байдлыг газар дээр нь судалж, санал, дүгнэлт гаргах" | | | | | | Үгүй | |
| **ЗГ-ын хуралдааны тэмдэглэл** | | | | | | | | | | |
| 108 | 166 | 2021 оны3 дугаар сарын 3-ны өдөр 14 дүгээр тэмдэглэл<br>2021-03-03<br>Дугаар 2021_14 | XII.3.4. Аялал жуулчлалын үр ашгийг нэмэгдүүлж, улирлын хамаарлыг бууруулах асуудлын хүрээнд олон улсын хэмжээний урлаг, соёл, спорт, хурал зөвлөгөөн, үзэсгэлэн зэрэг арга хэмжээг жуулчны идэвхгүй улирал буюу жил бүрийн 9 дүгээр сараас 5 дугаар сарын хооронд төлөвлөж, зохион байгуулах, энэ хугацаанд олон улсын нислэгийн хөнгөлөлттэй үнэ санал болгох талаар холбогдох шийдвэрийн төсөл боловсруулж, Засгийн газрын хуралдаанд хэлэлцүүлэхийг Байгаль орчин, аялал жуулчлалын сайд Н.Уртнасан, Зам тээврийн хөгжлийн сайд Л.Халтар, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч Д.Сумъяабазар нарт; | УБТЗ | Олон улсын хэмжээний Төмөр замын хамтын ажиллагааны байгууллага(ТЗХАБ)-ын ачааны хэмжээ тохиролцох зөвлөгөөнийг аялал жуулчлалын бус улиралд буюу 2025 оны 3 дугаар сард зохион байгуулсан. Эээлжит Монгол,ОХУ, Хятадын төмөр замуудын төлөөлөгчдийн зөвлөгөөнийг мөн 2025 оны 08 сарын сүүлээр зохион байгуулахаар төлөвлөж байна.<br>Мөн аялал жуулчлалын үр ашгийг нэмэгдүүлэх ажлын хүрээнд "ХНН" УБТЗ-ын Аялал жуулчлалын төв нь 2025 оны 01 дүгээр сарын 01-нд Шинэ оны нар харах "Нарны галт тэрэг" аяллыг зохион байгуулсан. Энэхүү аялалд Монгол дахь АНУ-ын консулын газрын | | | | Үгүй | |
| | | | | АТҮТ | Тус үйлдвэрийн газраас олон улсын хэмжээний урлаг, соёл , спорт, хурал , зөвлөгөөн, үзэсгэлэн зэрэг арга хэмжээг тайлант хугацаанд зохион байгуулаагүй бөгөөд үүргийн биелэлтийг хангаж ажиллаж | | | | | |

| | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | МИАТ | Аялал жуулчлалыг дэмжих болон бусад олон улсын хэмжээний урлаг, соёл, спорт, хурал зөвлөгөөн, үзэсгэлэн зэрэг арга хэмжээнд зориулж олон улсын нислэгийн тийзний тусгай тарифийг (01-04 сар, 10-04 сар) 4 болон түүнээс дээш хүнд 19-44 хувийн хямд үнийн тариф болон Истанбул, Франфурт, Хонконг, Бээжин, Токио, Сөүл, Бусан, Бангкок, Пукет, Хошимин чиглэлд 8+1 групп зорчигчийн урамшуулал гарган зах зээлд нэвтрүүлэн үр дүнтэй хэрэгжүүлэн ажиллаж байна. | | | | | |
| 109 | 167 | 2021 оны 6 дугаар сарын 8-ны өдөр 34 дүгээр тэмдэглэл 2021-06-08 Дугаар 2021_34 | YIII.5.1. . Хөдөлмөрийн тухай хуулийн 111 дүгээр зүйлд заасныг хэрэгжүүлж ажиллах, энэ хүрээнд өөрийн эрхэлсэн салбарын төрийн захиргааны төв байгууллага болон төрийн захиргааны байгууллагад нэг буюу түүнээс дээш тооны хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг ажиллуулах зохион байгуулалтын арга хэмжээ авахыг Засгийн газрын нийт гишүүдэд; (“Хөгжлийн бэрхшээлтэй хүний талаар 2021-2024 онд авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний талаар Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд А.Ариунзаяа Засгийн газрын гишүүдэд танилцуулав. ) | ХХ | Хөдөлмөрийн тухай хуулийн 111 дүгээр зүйлд заасны дагуу тус яам архивын туслахыг томилон ажиллуулж байна. | | | | Үгүй | |
| | 168 | | YIII.5.2 . Хөгжлийн бэрхшээлтэй хүний нийгмийн харилцаанд оролцох тэгш эрхийг хамгаалж, холбогдох хууль тогтоомж, стандартын хэрэгжилтийг эрхэлсэн салбар, харьяалах нутаг дэвсгэртээ хангуулах, хяналт тавьж ажиллахыг Засгийн газрын гишүүд, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт; | хх | 1.Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах зөвлөлийн 2025 оны 02 дугаар сарын 13-ны өдрийн тогтоолоор баталсан “Хөгжлийн бэрхшээлтнй хүний эрхийг хангах үндэсний зөвлөлийн 2025 оны үйл ажиллагааны төлөвлөгөө”-г хүлээн авч ЗТЯ-ны Дэд зөвлөл 2025 оны 4 дүгээр сарын 22-ны өдөр хуралдсан.<br>2.Дэд зөвлөлийн дарга бөгөөд Төрийн нарийн бичгийн даргын 2025 оны 04 дүгээр сарын 24-ний өдрийн А/124 дүгээр тушаалаар “Дэд зөвлөлийн 2025 оны үйл ажиллагааны төлөвлөгөө”-г батлуулсан.<br>3.Төлөвлөгөөний дагуу Зам, тээврийн яамны албан хэрэгцээнд хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн “Хараагүй хүмүүсийн хөдөлмөр сургалт үйлдвэрлэлийн төв”-ийн үйлдвэрлэсэн 7.300,00 төгрөгийн бичиг хэргийн дугтуй, архивын бичиг хэргийн хавтасыг худалдан авсан | | | | Үгүй | |
| 110 | 169 | 2022 оны 3 дугаар сарын 2-ны өдөр 14 дүгээр тэмдэглэл 2022-03-02 Дугаар 2022_14 | XIY.4.2. Орон нутгийн нисэх буудлын хүчин чадал, ашиглалтыг сайжруулах төслийг төр, хувийн хэвшлийн түншлэлээр хэрэгжүүлэх, Увс аймгийн “Дэглий цагаан”, Хэнтий аймгийн “Өндөрхаан” нисэх буудалд хилийн агаарын замын олон улсын боомт байгуулах, нисэх буудлын ашиглалтыг сайжруулах арга хэмжээ авахыг Сангийн сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайдын үүрэг хариуцагч Б.Жавхлан, Хууль зүй, дотоод хэргийн сайд Х.Нямбаатар, Зам, тээврийн хөгжлийн сайд Л.Халтар нарт даалгав. | ИНБЗГ | "1.“Ховд”, “Мөрөн”, “Чойбалсан нисэх буудлыг 4C, “Гурвансайхан” нисэх буудлыг 4D ангиллын болгон ашиглалтыг сайжруулах төслийн мэдээллийг Засгийн газрын 2023 оны 404 дүгээр тогтоолоор баталсан "Түншлэлээр хэрэгжүүлэх төслийн бүрэн шинжилгээ хийх журам"-ын дагуу боловсруулж, 2025 оны 05 дугаар сарын 01-ний өдрийн 03/2018 албан бичгээр ЭЗХЯ-нд хүргүүлсэн. 2.Дэглий цагаан нисэх буудалд олон улсын агаарын замын боомт байгуулах хүрээнд БСҮХорооноос 2023 онд шийдвэр гаргуулж, тэр дагуу ЗГ-ын хуралдаанаар хэлэлцүүлэх бэлтгэл ажлыг хангаж, УИХ-ын тогтоолын төслийн үзэл баримтлалыг 3 сайдаар батлуулсан, | | | | Үгүй | |
| 111 | 170 | 2022 оны 3 дугаар сарын 23-ны өдөр 17 дугаар тэмдэглэл 2022-03-23 Дугаар 2022_17 | IX.4.2. “Шинэ сэргэлтийн бодлого”-ын боомтын сэргэлтийн хүрээнд Цагааннуур, Даянгийн боомтуудыг хатуу хучилттай авто замаар холбож, эдгээр боомтын нэвтрүүлэх хүчин чадлыг нэмэгдүүлэх талаар холбогдох арга хэмжээ авч ажиллахыг Сангийн сайд Б.Жавхлан, Зам, тээврийн хөгжлийн сайд Л.Халтар, Гадаад харилцааны сайд Б.Батцэцэг нарт; | АЗБЗГ | Цагааннуур-Улаанбайшинт чиглэлийн 25.8км авто замыг 2022 ашиглалтад оруулснаар Цагааннуур боомт хатуу хучилттай авто замаар холбогдсон. Даян боомт чиглэлийн авто замын маршрутын судалгаа болон зураг төсөл боловсруулах зардлын тооцоог гарган Барилга хот байгуулалтын яаманд 2022.04.14-ны өдрийн "Санхүүжилт шийдвэрлүүлэх тухай" 01/1632 дугаартай албан тоотыг хүргүүлсэн боловч санхүүжилт нь шийдэгдээгүй. Харин Баян-Өлгий аймгийн ЗДТГ-аас авто замын зураг төслийг захиалан хийлгэсэн бөгөөд тус чиглэлийн авто замын эхний хэсэг болох Өлгий-Сагсай-Улаанхус-Цэнгэл сум чиглэлийн 80 км хатуу хучилттай авто замын барилгын ажилд шаардлагатай санхүүжилтийг 2024 оны Улсын төсвийн тухай хууль тусгуулахаар санал хүргүүлж, Өлгий-Сагсай-Улаанхус-Цэнгэл сум чиглэлийн хатуу хучилттай авто замын дөрөвдүгээр хэсэг, 23.13 км /Баян-Өлгий/ замын ажлыг 2024-2026 он хэрэгжүүлэхээр 2024 оны Улсын төсвийн тухай хуульд тусгасан | | | | Үгүй | |

| | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 112 | 171 | 2022 оны 5 дугаар сарын 4-ний өдөр 27 дугаар тэмдэглэл 2022-05-04 Дугаар 2022_27 | XYIII.2.13. Төрийн хүнд суртлыг арилгах, авлигаас ангид байх, төрийн үйлчилгээг иргэдэд шуурхай хүргэх, иргэд, аж ахуйн нэгж, байгууллагын санал, хүсэлтийг шуурхай шийдвэрлэхэд онцгой анхаарч, шаардлагатай арга хэмжээг авч тухай бүр нь хэрэгжүүлж ажиллахыг Засгийн газрын гишүүдэд; | ТЗУГ | “Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай” хууль, “Иргэдийн өргөдөл, гомдлыг шийдвэрлэхтэй холбогдсон зарим арга хэмжээний тухай “ Засгийн газрын 2005 оны 67 дугаар тогтоолын хүрээнд Зам, тээврийн хөгжлийн яам, агентлаг болон холбогдох албан тушаалтанд хандсан өргөдөл, гомдол, мэдээлэл, саналуудыг иргэдээс бичгээр, биечлэн, утсаар, цахим шуудангаар, вэбсайтаар, 11-11 төвөөр хүлээн авч хуулийн хугацаанд нь шийдвэрлэн хариу өгч байна. Тайлант хугацаанд тус яаманд нийт 176 өргөдөл ирүүлснээс шийдвэрлэсэн 159, хугацаа болоогүй 17 өргөдөл байна. Шийдвэрлэлт 90.3 хувьтай байна.<br>2.ЗГ-ын иргэд, олон нийттэй харилцах-11-11 төвд нийт 841 өргөдөл хуваарилснаас шийдвэрлэсэн 798, шийдвэрлэлт 94,8 хувьтай | | | | Үгүй | |
| 113 | 172 | 2022 оны 6 дугаар сарын 8-ны өдөр 32 дугаар тэмдэглэл 2022-06-08 Дугаар 2022_32 | XY.7. .<br>Монгол Улсын Сангийн яам, БНХАУ-ын Хөгжил, шинэчлэлийн хороотой 2022 оны 5 дугаар сарын 20-ны өдөр хийсэн цахим уулзалтын талаар Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Г.Ёндон Засгийн газрын гишүүдэд танилцуулав. Үүнтэй холбогдуулан:<br><br>1. Шивээхүрэн-Сэхэ төмөр замын боомтын бүтээн байгуулалтын төслийн урьдчилсан техник, эдийн засгийн үндэслэлийг боловсруулж дуусган холбогдох баримт бичгийг Хятадын талд хүргүүлэхийг “Монголын төмөр зам” ТӨХК (П.Ганхүү)-д, төслийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Зам, тээврийн хөгжлийн сайд Л.Халтарт даалгав; | тзг | Монгол Улсын Өмнөговь аймгийн Гурвантэс сумын 5-р баг, Шивээхүрэн боомтын нутаг дэвсгэрт Засгийн газрын 2018 оны 232 дугаар тогтоолын дагуу баригдсан “Хилийн Шивээхүрэн-Сэхээ боомтын хил дамнасан төмөр замын төсөл”-ийн Шивээхүрэн өртөөний нийт-19.2км доод болон дээд бүтэц, дохиолол холбоо, ачиж буулгах терминалын талбай, гэрэлтүүлгийг Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын сайдын 2024.12.03-ны өдрийн 118 тоот тушаалаар байгуулагдсан комисс ажиллаж байнгын ашиглалтад хүлээн авч 2024.12.20-ны өдрийн 2024/24 дугаар актаар баталгаажуулсан.<br>ЗТС-ын 2025.01.13-ны 01/154 тоот албан бичгээр БНХАУ-ын Үндэсний Хөгжил шинэчлэлийн хорооонд ШХ-СХ боомтын хил дамнасан төмөр замын байгуулалтын асуудлаар төмөр замын байгууллагууд уулзах тухай хүсэлтийг хүргүүлсэн. Хятадын талаас ГС-ГМ боомтын хил дамнасан төмөр замын бүтээн байгуулалт | | | | Үгүй | |
| 114 | 173 | 2022 оны 8 дугаар сарын 3-ны өдөр 39 дүгээр тэмдэглэл 2022-08-03 Дугаар 2022_39 | XYIII.3.11. Хөгжлийн төслүүдийн хэрэгжих байршил, төслийн нийт төсөвт өртөг, санхүү, эдийн засгийн үзүүлэлтүүд, техник, эдийн засгийн үндэслэл, ажлын зураг, газар, байгаль орчны үнэлгээ, дэд бүтэц, төслийн хүрээнд барьж байгуулах барилга байгууламж, бий болгох бүтээгдэхүүн, үйлчилгээ, зах зээлийн төлөв байдал болон холбогдох судалгаа, шинжилгээний мэдээлэл бүхий танилцуулгыг англи хэл дээр бэлтгэн 2022 оны 8 дугаар сард багтаан Гадаад харилцааны яам, Эдийн засаг, хөгжлийн яам, Сангийн яаманд тус тус хүргүүлэхийг холбогдох Засгийн газрын гишүүдэд; | БТГ | Сангийн яаманд Японы Олон улсын хамтын ажиллагааны байгууллагын санхүүжилтээр Японы 2025 оны санхүүгийн жилд хэрэгжүүлэх төслийн саналыг 2025 оны 6 дугаар сарын 5-ны өдөр Төрийн нарийн бичгийн даргын 03/2629 дугаар албан бичгээр хүргүүлсэн. Албан бичгээр Чингис хаан Олон улсын нисэх буудлын өргөтгөл болон Агаарын замын хяналтын хоёр дахь төвийн барилгын ажлын төслийн танилцуулгыг англи хэлээр хүргүүлсэн. | | | | Үгүй | |
| 115 | 174 | 2022 оны 12 дугаар сарын 12-ны өдөр 60 дугаар тэмдэглэл 2022-12-21 Дугаар 2022_62 | 3. “Богдхан төмөр зам” төслийг “Улаанбаатар төмөр зам” ХНН-ээр хариуцуулан гүйцэтгүүлэх, тус төмөр замын шугамыг эцэслэн тохирох чиглэлээр оросын талтай ажиллаж, холбогдох хууль тогтоомжийн хүрээнд арга хэмжээ авахыг Зам, тээврийн хөгжлийн сайд С.Бямбацогт, Гадаад харилцааны сайд Б.Батцэцэг нарт; | УБТЗ | "Богдхан төмөр зам" төслийн урьдчилсан ТЭЗҮ -г хэлэлцүүлэх талаар "РЖД" НХН -ийн нэгдүгээр орлогч,"УБТЗ" ХНН -ийн ерөнхий хорооны дарга С.А.Павловд 2024.02.20-ний өдөр14/505 дугаартай албан бичгээр хүргүүлсэн.<br>"Богдхан төмөр зам" -ын урьдчилсан ТЭЗҮ -г хэлэлцэх 2 талын хамтарсан ажлын хэсгийн уулзалт хэлэлцүүлгийг 2024.03.06-07 -ны өдрүүдэд видео конференци хэлбэрээр зохион байгуулсан. Уулзалт хэлэлцүүлгийн үр дүнд Оросын талын ажлын хэсгийн гишүүдээс тавьсан асуудлын дагуу холбогдох мэдээллийг "УБТЗ" ХНН -ийн зүгээс бэлтгэн боловсруулж хүргүүлсэн.<br>Мөн урьдчилсан ТЭЗҮ -ийн талаар "РЖД" НХН -ээс №исх25057 дугаартай албан бичгээр ирүүлсэн 10 асуулга тодруулгын хариу тайлбарыг боловсруулж ЗТХ -ийн сайдын зөвлөх Д.Эрдэнэбатад | - | | | Үгүй | |

| | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 116 | 175 | 2022 оны 12 дугаар сарын 12-ны өдөр 63 дугаар тэмдэглэл 2022-12-28 Дугаар 2022_63 | XXXVII.3.. “Шинэ тойрог зам” төслийг хэрэгжүүлэх бэлтгэл ажлыг хангах арга хэмжээний талаар Зам, тээврийн хөгжлийн сайд С.Бямбацогт Засгийн газрын гишүүдэд танилцуулав.<br><br>Үүнтэй холбогдуулан “Шинэ тойрог зам” төслийг хэрэгжүүлэх бэлтгэл ажлыг хангахад шаардагдах хөрөнгийн эх үүсвэрийг хамтран судалж, саналаа Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэхийг Зам, тээврийн хөгжлийн сайд С.Бямбацогт, Сангийн сайд Б.Жавхлан, Эдийн засаг, хөгжлийн сайд Ч.Хүрэлбаатар, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагч Д.Сумъяабазар нарт даалгав. | АЗБЗГ | Засгийн газрын 2022 оны 12 дугаар сарын 21-ний өдрийн 476 дугаар тогтоолын 3 дугаар заалтад “Шинэ тойрог зам” төслийн урд хэсэг, Туулын авто замыг “Төрийн өмчийн концессын зүйлийн жагсаалт”-д тусгаж, гүйцэтгэгч шалгаруулахыг Шадар сайд бөгөөд Эдийн засгийн хөгжлийн сайд болон Зам, тээврийн хөгжлийн сайд нарт даалгасан. ЗГ-ын 2023.07.05-ны өдрийн Засгийн газрын хуралдаанд төслийн явцын талаар танилцуулсан бөгөөд Төрийн өмчийн концессын зүйлийн жагсаалтад нэмэлтээр тусгасан Засгийн газрын 253 дугаар тогтоолыг гаргуулсан. | | | | Үгүй | |
| 117 | 176 | 2023 оны 1 дүгээр сарын 18-ны өдөр 4 дүгээр тэмдэглэл 2023-01-18 Дугаар 2023_4 | X.2.3. Тавантолгой-Гашуунсухайт, Тавантолгой-Цагаанцав-Ханги чиглэлийн төмөр замын экспортын ачаа тээвэрлэлтийг нэмэгдүүлэхэд шаардлагатай 4 зүтгүүрийг эхний ээлжид худалдан авах асуудлыг холбогдох хууль, журамд нийцүүлэн судалж, шийдвэрлэх саналаа танилцуулахыг Зам, тээврийн хөгжлийн сайд С.Бямбацогт, “Монголын төмөр зам” ТӨХК-ийн гүйцэтгэх захирал П.Ганхүү нарт; | ТЗДТБЗГ | Тавантолгой төмөр зам ХХК-д шаардлагатай 2 ширхэг зүтгүүрийг "Инкон" ХХК-аас түрээсээр авч ашиглаж байна. Мөн "Тавантолгой төмөр зам" ХХК-ийн худалдан авч буй 16 ширхэг зүтгүүрийн 4 ширхэг нь 2023.11.15-ны өдөр АНУ-аас ачигдсан бөгөөд SD70ACE/LW серийн эхний 4 зүтгүүрийг Монгол Улсад хүлээн авсан. | | | | Үгүй | |
| | 177 | | X.2.4. “Улаанбаатар төмөр зам” ХНН-ийн ачаа болон зорчигч тээвэрлэлтийн тарифыг тус нийгэмлэгийн 2020-2025 оны дунд хугацааны тарифын бодлогын хүрээнд шийдвэрлэх, шаардлагатай бол уг бодлогод өөрчлөлт оруулах асуудлыг тус нийгэмлэгийн Ерөнхий хороогоор хэлэлцүүлэн шийдвэрлүүлэх арга хэмжээ авахыг Зам, тээврийн хөгжлийн сайд С.Бямбацогт, “Улаанбаатар төмөр зам” ХНН-ийн Замын дарга Х.Хэрлэн нарт; | УБТЗ | Уг шийдвэрийн дагуу “Улаанбаатар төмөр зам” ХНН-ийн ачаа болон зорчигч тээвэрлэлтийн тарифыг Нийгэмлэгийн 2020-2025 оны дунд хугацааны тарифын бодлогын хүрээнд бус зах зээлийн зарчимд нийцүүлэн нэмэгдүүлэх асуудлыг холбогдох байгууллагуудтай зөвшилцсөний үр дүнд ШӨХТГ-аас нийгмийн ач холбогдолтой ачаа тээврээс бусад бүлгийн ачаа тээврийн ашгийн түвшин 30 хувь байхаар, зорчигч тээврийн тарифыг 50 хувиар индексжүүлэх зөвшөөрлийг 2023.04.04-ний өдрийн 01 тоот тогтоолоор олгосон. Тус зөвшөөрлийг хэрэгжүүлэхээр Нийгэмлэгийн | | | | Үгүй | |
| | 178 | | X.2.5. “Улаанбаатар төмөр зам” ХНН-ийн ачаа тээвэрлэлтийн тарифын үнэ, бусад мэдээллийг олон нийтэд ил тод болгох, гааль, татварын цахим системтэй уялдуулах асуудлыг авч үзэж, холбогдох хууль тогтоомжийн хүрээнд шийдвэрлэх арга хэмжээ авахыг “Улаанбаатар төмөр зам” ХНН-ийн Замын дарга Х.Хэрлэнд; | УБТЗ | UBTZ.MN вэб сайтад хэрэглэгч ачаа тээврийн хөлс тооцоолох үйлчилгээний мэдээллийг нүүр хуудсанд ил гаргаж олон нийтэд ойлгомжтой хялбар болгосон. Дурын хүн төмөр замаар тээвэрлүүлэх ачааныхаа ачих, буух өртөө, тарифын бүлгийг сонгож тээврийн үнийг шууд тооцоолж хардаг болсон. Мөн үйлчлүүлэгч тээвэрлүүлэх ачааны тарифын бүлгээ мэдэхгүй тохиолдолд ачааны нэрийг бичиж ачааны мэдээллийн сангаас тарифын бүлгийн мэдээллийг жагсаалтаар харах боломжтой болгосон.<br>"УБТЗ" ХНН нь ГЕГ-т шинэчилсэн сүлжээний орчинд дараах мэдээлэл дамжуулж байгаа. Үүнд:<br>- Экспортоор гарч байгаа бүх бараа бүтээгдэхүүн;<br>- Хилээр гарах галт тэрэгний мэдээлэл;<br>- Вагон болон контейнерын мэдээлэл зэргийг ГЕГ-ын бүрдүүлэлтийн "CEPS" системд хүний оролцоогүй /API сервис/ дамжуулан илгээгдэж байна.<br>"УБТЗ" ХНН болон ГЕГ шинэчилсэн сүлжээний орчинд мэдээлэл дамжуулж байна. | | | | Үгүй | |
| | 179 | | X.1.2. Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 9.6.5-д заасны дагуу Улсын Их Хурлын 2020 оны 23 дугаар тогтоолоор баталсан “Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл” бодлогын баримт бичгийг эрхлэх асуудлын хүрээ, тухайн салбарт хэрэгжүүлэх төлөвлөгөөг батлан хэрэгжүүлэхийг Засгийн газрын гишүүд, Засгийн газрын агентлагийн дарга нарт даалгав. | БТГ | МУ-ыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл бодлогын баримт бичигт зам, тээврийн чиглэлээр тусгах төсөл арга хэмжээг Зам, тээврийн салбарын стратеги төлөвлөгөөнд тусгах Зам, тээврийн хөгжлийн сайдын 2020 оны А/231 дугаартай тушаалаар батлуулсан. | | | | Үгүй | |

| | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 118 | 180 | 2023 оны 1 дүгээр сарын 25-ны өдөр 5 дугаар тэмдэглэл 2023-01-25 Дугаар 2023_5 | X.1.3. Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичигт тусгасан зорилго, зорилтыг тухайн салбарт хэрэгжүүлэх төлөвлөгөөг боловсруулахдаа өөрийн эрхлэх асуудлын хүрээнд хамаарах арга хэмжээ, үйл ажиллагаа, тэдгээрийн тухайн оны хэрэгжилтийн шалгуур үзүүлэлт, хүрэх (зорилтот) түвшинг урьдчилан тодорхойлж, байгууллагын үйл ажиллагааны жилийн төлөвлөгөөнд тусгах, бусад төрийн захиргааны төв байгууллагын арга хэмжээтэй уялдуулах зорилгоор Эдийн засаг, хөгжлийн яамны саналыг тусган хэрэгжүүлэхийг Засгийн газрын гишүүд, Засгийн газрын агентлагийн дарга нарт даалгав. | БТГ | Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичигт тусгагдсан зам, тээврийн салбарын төсөл арга хэмжээг яамны жил бүрийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгахаас гадна зам, тээврийн салбарын стратеги төлөвлөгөө тусган хэрэгжүүлж байна. Мөн эзэнжүүлсэн болон нарийвчилсан төлөвлөгөөг батлуулан ажиллаж байна. | | | | Үгүй | |
| | 181 | | X.2.2. Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд туссан хэрэгжилт удаашралтай байгаа арга хэмжээний хэрэгжилтийг эрчимжүүлж, тухайн жилд хүргэхээр тооцсон зорилтот түвшинд хүргэх арга хэмжээг зохион байгуулж ажиллахыг Засгийн газрын гишүүд, Засгийн газрын холбогдох агентлагийн дарга нарт үүрэг болгов. | БТГ | Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр, тус хөтөлбөрийг хэрэгжүүлэх төлөвлөгөөнд тусгагдсан зам, тээврийн салбарын төсөл арга хэмжээг 2020-2024 оны улсын төсөв, гадаад зээл тусламж, ТХХТ-ийн хүрээнд хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулан ажилласан. | | | | Үгүй | |
| | 182 | | X.3.. Хөгжлийн жилийн төлөвлөгөөнд тусгагдсан өөрийн эрхэлсэн асуудлын хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний нарийвчилсан төлөвлөгөөг гарган, хэрэгжилтийг оны эхнээс жигд ханган ажиллах, хэрэгжилт хангалтгүй төсөл, арга хэмжээг дараа жилийн төлөвлөгөөнд тусган бүрэн хэрэгжүүлж дуусгахыг Засгийн газрын холбогдох гишүүдэд даалгав. | БТГ | Монгол Улсын 2024 оны хөгжлийн төлөвлөгөөнд тусгагдсан зам, тээврийн салбарын төсөл арга хэмжээг хэрэгжүүлэх зам, тээврийн салбарын нарийвчилсан төлөвлөгөөг боловсруулан Зам, тээврийн хөгжлийн сайдаар батлуулсан. | | | | Үгүй | |
| 119 | 183 | 2023 оны 2 дугаар сарын 1-ний өдөр 6 дугаар тэмдэглэл 2023-02-01 Дугаар 2023_6 | XIY.1.3. Төрийн байгууллагууд болон зөвлөх үйлчилгээний захиалгаар хийлгэсэн судалгааны ажлын тайланг судалгааны нэгдсэн сангийн системд байршуулах, хянах, засварлах, хэрэглэгчийн саналыг хүлээн авах ажлыг холбогдох албан тушаалтанд хариуцуулж ажиллуулахыг Засгийн газрын гишүүд, Засгийн газрын агентлагийн дарга болон аймаг, нийслэлийн Засаг дарга нар, төрийн болон төрийн өмчийн оролцоот хуулийн этгээд, компани, үйлдвэрийн газрын удирдлагад; | СССХ | Зам, тээврийн салбарын хэмжээнд хийгдсэн судалгааны нэгдсэн санг бүрдүүлж https://sudalgaa.gov.mn/ сайтад нийт 72 судалгааг байршуулж нийтэд ил болгоод байна.Мөн 2024 онд яамны төсвийн хөрөнгөөр "Зам, тээврийн дэд бүтэц аймгуудын өрсөлдөх чадварт нөлөөлөх нь судалгаа", "Дэлхийн улс орнуудын өрсөлдөх чадварт зам, тээврийн салбарын үзүүлж буй нөлөөллийг тодорхойлох судалгаа" мэргэжлийн байгууллагаар хийлгэж акт үйлдэж тайланг хүлээн авсан. | | | | Үгүй | |
| 120 | 184 | 2023 оны 2 дугаар сарын 20-ны өдөр 9 дүгээр тэмдэглэл 2023-02-20 Дугаар 2023_9 | III.6. Засгийн газрын бодлого, шийдвэр нийгмийн хүлээлттэй хэрхэн уялдаж байгаа талаар судалгаа хийж, гарсан дүн шинжилгээнд тулгуурлан үндэслэл бүхий тайлбар, холбогдох мэдээллийг олон нийтэд хүргэж байхыг Засгийн газрын гишүүдэд даалгав. | ТЗУГ | Албан ёсны сайт, цахим хуудсанд 432 мэдээ, мэдээлэл нийтэлсэн болно.<br>Үүнээс хэвлэл мэдээллийн хэрэгслүүдээр дамжуулж, олон нийтэд түгээсэн мэдээ, мэдээллийн тоо 800, давтамж 1,500 удаа, нийт үзэлт давтагдсан тоогоор 8 сая. | | | | Үгүй | |
| | | | XY.6. 2023-2024 оныг “Монголд зочлох жил” болгон зарласантай уялдуулан Монголын иргэний агаарын тээврийн “МИАТ” ТӨХК-ийн үйлчилгээг сайжруулах арга хэмжээ авахыг Зам, тээврийн хөгжлийн сайд С.Бямбацогт, “МИАТ” ТӨХК (Б.Мөнхтамир)-д даалгав. | МИАТ | МИАТ ТӨХК нь 2023 онд Олон улсын хуваарьт 11 чиглэлд, захиалгат 14, Орон нутгийн 8 чиглэлд, захиалгат 1 чиглэлд, 3223 удаагийн нислэг үйлдэж, 895,329 зорчигч тээвэрлэсэн. (Өмнөх онтой харьцуулахад 102 хувь өссөн байна).<br>2023 онд хуваарьт болон захиалгат 1824 удаагийн нислэгээр 9449 тонн ачаа тээвэрлэсэн. (Өмнөх онтой харьцуулахад 47 хувь өссөн | | | | | |

| | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 121 | 185 | 2023 оны 3 дугаар сарын 1-ний өдөр 10 дугаар тэмдэглэл 2023-03-01 Дугаар 2023_10 | | ИНБЗГ | Үндэсний агаарын тээвэрлэгч МИАТ ТӨХК “Монголд зочлох жил”-ийн хүрээнд аялал жуулчлалыг дэмжих зорилгоор 2008 онд зогсоосон орон нутгийн нислэгээ дахин сэргээж 2023.06.30-ны өдрөөс эхлэн 8 аймгийн чиглэлд долоо хоногийн 2-3 удаагийн давтамжтайгаар тогтмол хуваарьт нислэг үйлдэж эхлэсэн.<br>МИАТ ТӨХК үндэсний агаарын тээвэрлэгчийн хувьд нийгмийн хариуцлагын хүрээнд харьцангуй хямд үнийг санал болгож байна. Тухайлбал: өмнө нь Өлгий, Ховд чиглэлд нислэгийн тийз хоёр талдаа 1,5-1,7 сая байсан бол 810,000-902,000, Улаангом, Улиастай руу 1.3-1.4 сая байсан бол 633,000-852,000 болж 2-2,5 дахин хямдруулсан. Мөн Даланзадгад руу хоёр талдаа 500,000-617,000, Мөрөн рүү 500,000-680,000, Алтай руу 733,000-852,000, Чойбалсан руу 537,000-617,000 төгрөгний тарифаар нислэг үйлдэж байна.<br>МИАТ ТӨХК нь 2024 онд орон нутгийн чиглэлд нислэг үйлдэх 70 хүний суудалтай CRJ-700 маягийн 1 агаарын хөлөг авахаар төлөвлөн агаарын хөлгийг 2024.03.27-ны өдөр хүлээн авсан бөгөөд агаарын хөлгийн нислэгт тэнцэх чадварын гэрчилгээжих хүрээнд нислэг техникийн бэлтгэл ажил, бичиг баримтын бүрдүүлэлтийн хийж гүйцэтгэн ИНЕГ-т шалгуулж, нислэгийн зөвшөөрөл авсан.<br>Уг агаарын хөлгөөр 2024.04.28-ны өдөр эхний нислэгийг УБ-Ховд-УБ чиглэлд үйлдсэн.<br>МИАТ ТӨХК ийнхүү Монголд зочлох жил болон Бүсчилсэн хөгжлийг дэмжих бүтээн байгуулалтын жилийн хүрээнд орон нутгийн 8 | | | | Үгүй | |
| 122 | 186 | 2023 оны 3 дугаар сарын 07-ний өдөр 11 дүгээр тэмдэглэл 2023-03-07 Дугаар 2023_11 | XII.5. Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хууль болон салбарын бодлого, стратегийн төлөвлөгөө, Жендэрийн үндэсний хорооны 2023 оны ээлжит хуралдаанаас гарсан шийдвэрийг хэрэгжүүлэхэд анхаарч ажиллахыг Засгийн газрын гишүүд, яамдын жендэрийн салбар зөвлөл, орон нутгийн салбар хорооны дарга, Жендэрийн үндэсний хорооны гишүүдэд тус тус даалгав. | ХХ | 1.Зам, тээврийн яамны жендэрийн салбар зөвлөлийн үйл ажиллагааны төлөвлөгөөг ТНБД-аар 2025 оны 04 дүгээр сарын 01-ний өдөр батлуулсан.<br>2.Төлөвлөгөөнд тусгасаны дагуу /урьдчилан/ Зам, тээврийн салбарын эмэгтэйчүүдийн зөвөлгөөнийг 2025 оны 3 дугаар сарын 10-ны өдөр зохион байгуулсан.<br>3.Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуульд заасны дагуу 2025 оны 01 дүгээр сарын 10-нд салбар зөвлөлийн тайланг Жендэрийн үндэсний хороонд хүргүүлсэн.<br>4.Төлөвлөгөөний дагуу ЗТЯ-ны албан хаагчдыг эрүүл мэндийн үзлэгт хамруулах ажлыг  2025 оны 04 дүгээр сарын 29-30-ны өдрүүдэд  зохион байгуулж 114 албан хаагчийг хамруулсан.<br>5.Ерөнхий сайдын 2024 оны 71 дүгээр захирамжаар батлагдсан “Эрэгтэй эмэгтэй хүний дундаж наслалтын зөрүүг багасгах талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө”-г хэрэгжүүлэх төлөвлөгөөг Жендэрийн салбар зөвлөлийн даргаар батлуулсан.<br>6.Жендэрийн салбар зөвлөлийн 2025 оны батлагдсан төлөвлөгөө, тайланг абле-д байршуулаад байна.<br>7.Зам, тээврийн яаманд шинээр орсон албан хаагчдад зориулсан | | | | Үгүй | |
| | 187 | | XII.1.1. Гадаад валютын улсын нөөцийг нэмэгдүүлэх чиглэлээр авах зарим арга хэмжээний тухай” Засгийн газрын 2022 оны 10 дугаар сарын 5-ны өдрийн 362 дугаар тогтоолын хэрэгжилт, цаашид авах арга хэмжээний талаар Монгол Улсын Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайд Ч.Хүрэлбаатар Засгийн газрын гишүүдэд танилцуулав. Үүнтэй | ТТЗ | | | | | | |
| | | | | УБТЗ | | | | | | |
| | | | | МТЗ | "Монголын төмөр зам" ТӨХК-ийн өөрийн эзэмшлийн нийт  215 хагас вагон байгаагаас 200 хагас вагоныг "Дархан төмөрлөгийн үйлдвэр" ХХК-ийн Төмөртэй-Эрээн чиглэлийн экспортын төмрийн хүдэр | | | | Үгүй | |
| | 188 | | XII.1.2. “Улаанбаатар төмөр зам” ХНН-ийн ачаа болон зорчигч тээвэрлэлтийн тарифыг зах зээлийн зарчимд нийцүүлэн нэмэгдүүлэх асуудлыг “Улаанбаатар төмөр зам” ХНН-ийн Ерөнхий хороогоор хэлэлцүүлэн шийдвэрлүүлэх арга хэмжээ авахыг Зам, тээврийн хөгжлийн сайд С.Бямбацогт, “Улаанбаатар төмөр зам” ХНН (Х.Хэрлэн)-т даалгав. | УБТЗ | Уг үүрэг даалгаврын хүрээнд 2023 оны 06 дугаар сард зохион байгуулагдсан Монгол-Оросын ХНН Улаанбаатар төмөр замын Ерөнхий хорооны ээлжит хуралдааны үеэр дотоодын харилцааны ачаа тээвэрлэлтийн 8 бүлгийн тарифыг индексжүүлэх, транзит тээвэрлэлтийн хөнгөлөлтийн хувь хэмжээг  бууруулах, олон улсын болон орон нутгийн харилцааны зорчигч тээвэрлэлтийн тарифыг индексжүүлэх шийдвэр гарсан. Үүний дагуу  ШӨХТГ-ын 2023.04.04-ний өдрийн 01 тоот тогтоолоор Нийгэмлэгийн дотоодын харилцааны ачаа тээвэрлэлтийн 16 бүлгийн тарифыг 8-83 хувиар, олон улсын болон орон нутгийн харилцааны зорчигч тээвэрлэлтийн тарифыг 50 хувиар индексжүүлэх зөвшөөрлийг олгосон. Улмаар Замын даргын 2023.06.23-ны өдрийн  А/593, А/594, А/598, А/602, А/604,А/972,   тоот тушаалууд гарч 2023.07.01-ний өдрөөс мөрдөн ажиллаж эхэлсэн нь | | | | Үгүй | |

| | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 123 | 189 | 2023 оны 3 дугаар сарын 29-ний өдөр 14 дүгээр тэмдэглэл 2023-03-29 Дугаар 2023_14 | XVIII.7.3. Монгол Улсын Ерөнхий сайд Л.Оюун-Эрдэнийн Монгол Улсад үйл ажиллагаа явуулж буй олон улсын байгууллагын ажилтнуудтай 2023 оны 3 дугаар сарын 27-ны өдөр хийсэн уулзалтын талаар Гадаад харилцааны сайд Б.Батцэцэг Засгийн газрын гишүүдэд танилцуулав.<br><br>Үүнтэй холбогдуулан дараах арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг Засгийн газрын холбогдох гишүүдэд даалгав:<br>3.Олон улсын байгууллагын техник туслалцааны төслийн хүрээнд гадаад улсад магистр, доктор болон ахисан түвшний сургалтад хамрагдсан төрийн албан хаагчдыг төгсмөгц, ажлын байранд нь эргүүлэн томилж ажиллуулах арга хэмжээ авч байхыг яамдын Төрийн нарийн бичгийн дарга, агентлагийн дарга нарт; | ТЗУГ | ЕСББ, АХБ-ний санхүүжилтээр нийт 26 албан хаагчдыг мэргэшүүлэх зорилгоор гадаад улсад туршлага судлах, мэргэшүүлэх сургалтад хамруулсан. | | | | Үгүй | |
| | 190 | | XVIII.7.4. Монгол Улсын Ерөнхий сайд Л.Оюун-Эрдэнийн Монгол Улсад үйл ажиллагаа явуулж буй олон улсын байгууллагын ажилтнуудтай 2023 оны 3 дугаар сарын 27-ны өдөр хийсэн уулзалтын талаар Гадаад харилцааны сайд Б.Батцэцэг Засгийн газрын гишүүдэд танилцуулав.<br><br>Үүнтэй холбогдуулан дараах арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг Засгийн газрын холбогдох гишүүдэд даалгав:<br>Олон улсын байгууллагын санхүүжилтээр хэрэгжүүлэх төслийн хүрээнд төрийн албан хаагчийг мэргэшүүлэх зорилгоор гадаад улсад туршлага | ТЗУГ | Б.Эрдэнэзаяа, Б.Цэнгэлмаа, Ц.Хосгэрэл, Б.Энх-Өлзий, Б.Нарантунгалаг, Л.Булганхүү, Б.Хулан, Б.Мэндбаяр нартай сургалтын гэрээ байгуулж амжилттай суралцаж магистрын зэрэг хамгаалж ирсэн албан хаагчдыг албан тушаалд нь эргүүлэн томилсон. Мөн Э.Бадамсүрэн, С.Баярчимэг, У.Эрдэнэбаатар нар гэрээ байгуулан суралцаж байна. | | | | Үгүй | |
| | 191 | | XVIII.9.1. Зүүнбаян-Ханги чиглэлийн төмөр замын бүтээн байгуулалтын ажлыг эрчимжүүлэх, хилийн Ханги-Мандал боомтын хил дамнасан төмөр замын бүтээн байгуулалтын ажлыг эхлүүлэх талаар Зам, тээврийн хөгжлийн сайд С.Бямбацогт Засгийн газрын гишүүдэд танилцуулав. Үүнтэй холбогдуулан:<br>Зүүнбаян-Ханги чиглэлийн төмөр замын бүтээн байгуулалтын ажлыг 2023 онд багтаан бүрэн дуусгаж, байнгын ашиглалтад оруулах талаар концесс эзэмшигчийг удирдамж, чиглэлээр хангаж ажиллахыг Зам, тээврийн хөгжлийн сайд С.Бямбацогтод даалгав; | ТЗДТБЗГ | Монгол Улсын Засгийн газраас хэрэгжүүлж буй “Шинэ сэргэлтийн бодлого”-ын Боомтын сэргэлтийн хүрээнд экспорт, импортын шинэ гарц болох Зүүнбаян-Ханги чиглэлийн 226,9 километр төмөр зам байнгын ашиглалтад орлоо.Тус чиглэлийн төмөр замын суурь бүтэц барих тусгай зөвшөөрөл болон төмөр замын суурь бүтцийн барилгын ажлын зөвшөөрлийг “Монголиан транс лайн” ХХК-д олгосон байна. Ингээд төмөр замын 235 цэгийн ус зайлуулах төмөрбетон хоолой, 4 цэгийн төмөрбетон гүүр, 14 сая м.куб газар шорооны ажлын бүтээн байгуулалтад дотоодын 40 гаруй аж ахуй нэгж барилга угсралт, барилгын материал нийлүүлэх ажилд хамтран ажиллажээ. Туршилтын тээврээр 2.6 сая тонн ачаа | | | | Үгүй | |
| 124 | 192 | 2023 оны 4 дүгээр сарын 5-ны өдөр 15 дугаар тэмдэглэл 2023-04-05 Дугаар 2023_15 | XI.2.3. Нийслэл Улаанбаатар хотод хэрэгжүүлэх “Сэлбэ сэргэлт” төслийн талаар Барилга, хот байгуулалтын сайд Ц.Даваасүрэн Засгийн газрын гишүүдэд танилцуулав. Үүнтэй холбогдуулан:Нийслэл Улаанбаатар хотын авто замын сүлжээний тодорхой хэсгүүдэд баригдах холбох авто зам болон “Шинэ тойрог зам” төслийн бүрэлдэхүүн Туул голын дагуух авто замын төслийн талаар Засгийн газрын дараагийн хуралдаанд танилцуулахыг Зам, тээврийн хөгжлийн сайд С.Бямбацогтод даалгав. | СХ | Төсвийн хөрөнгө оруулалтын удирдлагын систем (PIMIS) программыг ашиглаж байна. | | | | Үгүй | |
| | 193 | | XI.8.1. Улсын төсвийн хөрөнгө оруулалтын санхүүжилтийн явц болон төсвийн хөрөнгө оруулалтын удирдлагын цахим системийн ашиглалтын талаар Сангийн сайд Б.Жавхлан Засгийн газрын гишүүдэд танилцуулав.<br><br>Үүнтэй холбогдуулан Монгол Улсын 2023 оны төсвийн тухай хуулийн хэрэгжилтийг хангах, улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлж байгаа төсөл, арга хэмжээний гүйцэтгэлийг эрчимжүүлэх, төсвийн хөрөнгө оруулалтын удирдлагын цахим системийн ашиглалтыг бүх түвшинд сайжруулах чиглэлээр дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг доор дурдсан албан тушаалтанд даалгав:<br><br>Төсвийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг төлөвлөх, хэрэгжүүлэх, | СХ | Төсвийн хөрөнгө оруулалтын удирдлагын систем (PIMIS) программыг ашиглаж байна. | | | | Үгүй | |

| | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 125 | 194 | 2023 оны 4 дүгээр сарын 12-ны өдрийн 16 дугаар тэмдэглэл 2023-04-12 Дугаар 2023_16 | XIX.1. Нийслэлийн хүн амын 2023 оны хаврын улирлын хүнсний хэрэгцээнд зориулан бэлтгэсэн нөөцийн махыг худалдан борлуулах цэгийг нэмэгдүүлэх, төв цэнгэлдэх хүрээлэнд худалдаалах цэг гаргах, аймаг, орон нутгаас мах ачсан тээврийн хэрэгслийг нийслэл хот руу саадгүй нэвтрүүлэх, нөөцийн махны чанарын асуудлаар мэдээлэл хийх зэрэг арга хэмжээ авч ажиллахыг Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагч Д.Сумъяабазар, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Х.Болорчулуун нарт, уг ажилд хяналт тавьж ажиллахыг Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Д.Амарбаясгаланд даалгав.<br><br>Төрийн болон төрийн бус байгууллага, хувийн хэвшлийн төлөөлөлтэй хийх уулзалтын үеэр “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, Засгийн газрын “Шинэ сэргэлтийн бодлого”-ыг сурталчлан таниулж, хэрэгжилтийн явцын талаар мэдээлж ажиллахыг Засгийн газрын гишүүдэд даалгав.<br><br>Төрийн ордны хашааны засварын асуудлаар иргэд, олон нийтээс ирүүлж буй шүүмжлэлийг харгалзан үзэх, засварын ажлыг эрчимжүүлэх арга хэмжээ авч ажиллахыг Хууль зүй, дотоод хэргийн сайд Х.Нямбаатар, Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Д.Амарбаясгалан нарт даалгав.<br><br>Хөтөлийн цемент шохойн үйлдвэрийн үйл ажиллагаанд хийсэн аудитын тайлан, дүгнэлт, үйлдвэрийн захирлын асуудлаарх ажилчдын шаардлагыг нягтлан шалгаж, дүнг танилцуулахыг Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Д.Амарбаясгалан, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар (Б.Цэнгэл)-т даалгав. | ТЗУГ | Албан ёсны сайт, цахим хуудсанд 432 мэдээ, мэдээлэл нийтэлсэн болно.<br>Үүнээс хэвлэл мэдээллийн хэрэгслүүдээр дамжуулж, олон нийтэд түгээсэн мэдээ, мэдээллийн тоо 800, давтамж 1,500 удаа, нийт үзэлт давтагдсан тоогоор 8 сая байна. | | | | Үгүй | |
| 126 | 195 | 2023 оны 4 дүгээр сарын 19-ний өдөр 17 дугаар тэмдэглэл 2023-04-19 Дугаар 2023_17 | XIX.2.3. Хүний эрх, эрх чөлөөг зөрчсөн зөрчлийг арилгуулахаар Хүний эрхийн үндэсний комиссын гишүүнээс гаргасан шаардлага, зөвлөмжийг биелүүлж ажиллахыг Засгийн газрын гишүүд болон бүх шатны Засаг дарга нарт тус тус үүрэг болгов | ХХ | Хүний эрх эрх чөлөөг зөрчсөн зөрчлийг арилгуулахаар гаргасан зам, тээврийн салбарт хамаарах шаардлага, зөвлөмж ирээгүй байна. | | | | Үгүй | |
| | 196 | | XIX.1.1. Туулын авто замыг Нисэхийн хурдны авто замтай холбох авто замын төслийн (Наадамчдын авто зам дээгүүрх гүүрэн байгууламж) 800 у/м гүүрний ажлын санхүүжилтийн эх үүсвэрийг судалж, Засгийн газрын хуралдаанд танилцуулахыг Монгол Улсын Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайд Ч.Хүрэлбаатар, Сангийн сайд Б.Жавхлан, Зам, тээврийн хөгжлийн сайд С.Бямбацогт нарт; | АЗБЗГ | Туулын авто замыг Нисэхийн хурдны авто замтай холбох Наадамчдын гудамжны авто зам дээгүүр тавих 800 у/м гүүрийн зураг төслийг 2024.06.30-нд боловсруулж бүрэн дуусгаж, Нийслэлийн засаг даргын тамгын газарт 2024 оны 07 дугаар сарын 27-нд хүлээлгэн өгч ажилласан. | | | | Үгүй | |
| | 197 | | XIX.1.4. “Шинэ тойрог зам” төслийн урд хэсэг, Туулын авто зам болон Туулын авто замыг Нисэхийн хурдны авто замтай холбох (Туулын авто замаас Нүхтийн авто зам хүртэл) авто замын төслийн техник, эдийн засгийн үндэслэл, барилгын ажлын нарийвчилсан зураг төслийг баталгаажуулахад шаардлагатай холбогдох техникийн нөхцөлийг шуурхай олгож ажиллахыг Эрчим хүчний сайд Б.Чойжилсүрэн, Зам, тээврийн хөгжлийн сайд С.Бямбацогт, Барилга, хот байгуулалтын сайд Ц.Даваасүрэн, Цахим хөгжил, харилцаа холбооны сайд Н.Учрал, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагч Д.Сумъяабазар нарт; | АЗБЗГ | Концессын тухай хууль 2023.12.31-ний өдрөөс хүчингүй болж, Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хууль 2024.01.01-ний өдрөөс хүчин төгөлдөр мөрдөгдөж эхэлсэн. Мөн Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн дагуу концессын гэрээ байгуулагдаагүй, гарын үсэг зурагдаагүй төслүүдийг концессын тухай хуулийн хүрээнд цааш үргэлжлүүлэх боломжгүй нөхцөл байдал үүссэн. 2024 оны 02 дугаар сарын 13-ний өдрийн 1/623 дугаартай Сайдын албан бичгээр Нийслэлийн засаг даргын тамгын газарт Засгийн газрын 2022 оны 12 дугаар сарын 21-ний өдрийн 476 дугаар тогтоолын 3 дугаар заалтад туссан “Шинэ тойрог зам” төслийн урд хэсэг, Туулын авто замыг хэрэгжүүлэхээр шилжүүлсэн. Нийслэлийн ЗДТГ-аас захиалан | | | | Үгүй | |
| | 198 | | XIX.3.1. Хилийн Булган авто замын боомтод ачаа тээврийн терминал, авто цогцолбор байгуулах болон хил дамнасан авто замаар холбох өргөтгөл, шинэчлэлийн зураг төслийг Бүгд Найрамдах Хятад Ард Улсын боомтын төлөвлөлттэй уялдуулан боловсруулах, боомтын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг шинэчлэн боловсруулж, батлуулах арга хэмжээ авахыг Монгол Улсын сайд, Боомтын сэргэлтийн Үндэсний хорооны дарга Б.Тулга, Барилга, хот байгуулалтын сайд Ц.Даваасүрэн, Зам, тээврийн хөгжлийн сайд С.Бямбацогт нарт даалгав; | АЗБЗГ | Боомтын сэргэлтийн үндэсний хорооноос Булган хилийн боомтын ачаа, зорчигч тээврийн терминалыг сайжруулах ажлын хүрээнд Азийн хөгжлийн банкны хөнгөлөлттэй зээлээр Булган боомтын Ерөнхий төлөвлөгөө, нарийвчилсан зураг төслийг боловсруулан, 2026 оноос бүтээн байгуулалтын ажлыг эхлүүлэхээр төлөвлөн бэлтгэл ажлыг эхлүүлсэн байна. | | | | Үгүй | |

| | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | 199 | | XIX.3.2. Монгол Улс, Бүгд Найрамдах Хятад Ард Улсын хилийн 126 дугаар тэмдэгт орчмоор хил дамнасан авто зам байгуулах асуудлаар хятадын талтай хэлэлцээ хийхийг Гадаад харилцааны сайд Б.Батцэцэг, Монгол Улсын сайд, Боомтын сэргэлтийн Үндэсний хорооны дарга Б.Тулга, Зам, тээврийн хөгжлийн сайд С.Бямбацогт нарт даалгав; | АЗБЗГ | Монгол, Хятадын хилийн дэглэмийн тухай Монгол Улсын Засгийн газар, БНХАУ-ын Засгийн газар хоорондын гэрээний дагуу Гадаад харилцааны яам болон Боомтын үндэсний зөвлөлөөс БНХАУ-ын талтай хэлэлцээр хийж авто замаар хил огтлох асуудлыг харилцан тохиролцоно. ЗТХЯ-ны зүгээс шаардлагатай мэдээллээр ханган ажилласан. Хил огтлох цэгийг асуудлаар Хятадын талтай хэлэлцээ хийх нь Гадаад харилцааны сайдын бүрэн эрхийн асуудал юм. | | | | Үгүй | |
| 127 | 200 | 2023 оны 4 дүгээр сарын 26-ны өдөр 18 дугаар тэмдэглэл 2023-04-26 Дугаар 2023_18 | XIV.1.2. “Зам тээврийн ухаалаг систем RFID” төслийн хэрэгжилтийг эрчимжүүлж ажиллахыг Зам, тээврийн хөгжлийн сайд С.Бямбацогт, Монгол Улсын сайд, Нийслэл Улаанбаатар хотын авто замын түгжрэлийг бууруулах Үндэсний хорооны дарга Ж.Сүхбаатар, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагч Д.Сумъяабазар нарт. | АТБЗГ | 2025 онд олон улс, улсын чанартай авто замд төлбөр авах 33 цэгүүдэд RFID технологи хяналт тавих тоног төхөөрөмжи, сервер худалдан авах, суурлиулах, цахим системийн сайжруулалт, өргөтгөл, автотээврийн хяналтын улсын байцаагчийн хяналт бүртгэлийн систем шинээр хөгжүүлэх,мэдээллийн системийн сервер, тоног төхөөрөмж худалдан авах ажлууд хийгдэх ба зарим ажлын бэлтгэл хангаж байна | | | | Үгүй | |
| | 201 | | XYIII.2.2. Гааль, татварын нэгдсэн удирдлага, хяналтын системд бүртгэлтэй худалдан борлуулах болон тээвэрлэх үйл ажиллагаатай холбоотой гэрээний мэдээлэлд үндэслэн ухаалаг гарц суурилагдсан хилийн боомтууд дээр гаалийн бүрдүүлэлтийг автоматжуулах, шат дамжлагыг бууруулах зохион байгуулалтын арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг Гаалийн ерөнхий газар (Р.Отгонжаргал), Татварын ерөнхий газар (Б.Заяабал), Цагдаагийн ерөнхий газар (Ж.Болд), “Авто тээврийн үндэсний төв” ТӨҮГ (Б.Гүрсоронзон), “Гааль, татвар, санхүүгийн мэдээллийн технологийн төв” УҮГ (Т.Батбилэг)-т даалгав; | АТҮТ | Уул уурхайн бүтээгдэхүүний Гашуунсухайт, Шивээхүрэн боомтуудын экспортын тээвэрлэлтэд автомат удирдлагатай, жолоочгүй тээврийн хэрэгсэл буюу /Automatic Gueded Vehicle/ AGV нэвтрүүлсэн. Түүнчлэн Автотээврийн хяналтын улсын байцаагчийн дүгнэлтийг цахимжуулсан. Үүнтэй холбогдуулан гаалийн бүрдүүлэлтийг автоматжуулахад улсын байцаагчийн дүгнэлтийн мэдээллийг сервисээр өгөх боломжийг бүрдүүлсэн. Монгол улс болон БНХАУ-ын нийт 50 тээврийн хэрэгслээс Монгол талын 12, БНХАУ талын 38 тээврийн хэрэгсэл тээвэрлэлт гүйцэтгэж байна. 2025.06.20-ний өдрийн байдлаар Гашуунсухайт боомтоор 16.7 сая тн нүүрс тээвэрлэсэн ба үүнээс автомат удирдлагатай жолоочгүй тээврийн хэрэгслээр 27553 рейсийн ажил гүйцэтгэн 1.73 сая тн нүүрс тээвэрлээд байна. Шивээхүрэн боомтоор дээрх хугацаанд 12 сая тн | | | | Үгүй | |
| 128 | 202 | 2023 оны 5 дугаар сарын 03-ны өдөр 19 дүгээр тэмдэглэл 2023-05-03 Дугаар 2023_19 | XYIII.3.2. Шаардлагатай мэдээлэл, тайланг бэлтгэхэд оролцох албан хаагчийг томилон ажиллуулахыг холбогдох Засгийн газрын гишүүдэд даалгав.<br>(Авлигын төсөөллийн индексийг тооцоход нөлөө үзүүлэх шалгуур үзүүлэлт (индекс)-ийг тодорхойлоход оролцдог байгууллагуудтай хамтран ажиллах, уулзалт, хэлэлцүүлэг зохион байгуулах ажлын төлөвлөгөө гаргаж, холбогдон гарах зардлыг судлан Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэн шийдвэрлүүлэхийг Хууль зүй, дотоод хэргийн сайд Х.Нямбаатарт) | АТҮТ | Шаардлагатай мэдээлэл, тайланг бэлтгэхэд оролцох албан хаагчийг тус үйлдвэрийн газраас тухай бүр томилон ажиллуулж байна. Мөн ЗТЯ-тай хамтран тээврийн хэрэгслийн бүртгэлийн сангаас тухай бүр шаардлагатай тоон мэдээг гарган ажиллаж байна. | | | | Үгүй | |
